

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2005 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ
/2005.01.01.-2005.06.25./

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ

Мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, улсын төсвийн улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор 2005 оны төсвийн жилд 80 хүртэл тэрбум төгрөгийн үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Засгийн газрын тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэв.

Гадаадын хөрөнгө оруулагчийн Монгол Улсад оруулсан анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь 10.0 сая.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш бөгөөд 15 жилээр байгуулах Тогтвортой байдлын гэрээний загварыг баталж, мөрдүүлээ.

Япон Улсын Засгийн газраас олгож байгаа төслийн буцалтгүй тусламжаар бараа авах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгосон 300 сая иений төслийн бус тусламжийн хөрөнгөөр нефть бүтээгдэхүүн худалдан авах нь зүйтэй гэж үзэв.

Бүсийн хэлэлцээр байгуулах нийтлэг журам болон Бүсийн хөгжлийг дэмжих сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, хяналт тавих журмыг Засгийн газрын тогтоолоор баталж, мөрдүүлээ.

Азийн хөгжлийн банк /АХБ/-наас Монгол Улстай 2005-2008 онд явуулах хамтын ажиллагааны стратеги, хөтөлбөрийн дагуу АХБ Монгол Улсад жил бүр 28 сая ам.доллартай тэнцэхүйц хэмжээний хөнгөлөлттэй зээл олгож, 1,9 сая ам.доллартай тэнцэхүйц хэмжээний техникийн туслалцаа болон буцалтгүй тусламж үзүүлэхээр боллоо. Мөн санхүү, зам тээвэр, эрүүл мэнд, боловсрол, хот байгуулалт, төрийн захиргаа зэрэг салбарын хүрээнд төслүүд хэрэгжүүлэхээр тохиролцов.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх төслийн судалгааны ажлаар ирсэн Японы төлөөлөгчидтэй хэлэлцээ хийж, Багануур-Хэрлэнгийн зүүн ба Мөрөнгийн баруун-Өндөрхааны хооронд 77.4 км асфальтан хучилттай авто замыг барих, Зам, засвар арчлалтын төвийн хүчин чадлыг бэхжүүлэхэд шаардлагатай авто замын машин, механизмыг нийлүүлэх; Өгий нуур дээр судалгаа явуулах; Өмнөговь, Сайншанд, Улаанбаатарт судалгаа хийх; Татварын боловсролын тогтолцоог боловсронгуй болгох төслийн хүрээнд гүйцэтгэх ажлын хүрээг тохиролцлоо.

БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Бүс нутгийн автозамыг хөгжүүлэх” төслийн Засгийн газар хоорондын тохиролцооны баримт бичигт гарын үсэг зурав.

Ядуурлыг бууруулах итгэлцлийн сангийн үйл ажиллагааны хүрээнд “Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратеги болон нийгмийн даатгалын салбарын шинэчлэлийн стратегийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэлийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт нээлттэй форумыг зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үеэр Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигт тусгагдсан нийгмийн даатгалын салбарын шинэчлэлийн хүрээний стратегийн зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ярилцаж, нээлттэй форумд оролцогчид 10 зүйл бүхий зөвлөмж гаргав.

Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Сэргээн босголтын банк хооронд байгуулах “Орон нутгийн зам сайжруулах” төслийн зээлийн гэрээг зарчмын хувьд дэмжиж, УИХ-ын холбогдох Байнгын хороотой зөвшилцөн шийдвэр гарсны дараа гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрх олгох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг ажлын журмаар гаргахаар тогтсон.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн нийгэмлэгийн хооронд байгуулах “Малын индексжүүлсэн даатгалын төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийн тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд холбогдох талтай хэлэлцээ хийхээр боллоо.

АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл”-ийн зээлийн гэрээг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, соёрхон батлуулахаар УИХ-аар соёрхон батлуулав. Энэ гэрээний дагуу одоо барьж эхэлсэн Налайх-Чойрын чиглэлийн 200 км замыг үргэлжлүүлэн Замын-Үүд хүртэл 454 км авто замыг барихад АХБ, БНСУ, БНХАУ-ын Засгийн газар хамтарч ажиллахаар тохиролцсон. Замын-Үүд хүртэл засмал замыг барихад 78 сая гаруй ам.доллар шаардлагатай бөгөөд үүний 37,1 сая долларын санхүүжилтийн эх үүсвэрийг АХБ хөнгөлөлттэй зээлээр олгох болжээ. БНСУ-ын Засгийн газраас олгох 23,9 сая доллартай тэнцэх хөнгөлөлттэй зээл, БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар олгох 1,5 сая ам.доллар, Монгол Улсын Засгийн газрын гаргах 15,6 сая ам.долларын санхүүжилтээр урд хил хүртэлх хатуу хучилттай зам барихаар тооцов.

Худалдан авах ажиллагааны вэб боловсруулах зөвлөх компанитай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, тэднийг мэргэжил, аргазүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллан, <http://www.e-procurement.mn> гэсэн хаяг бүхий Засгийн газрын худалдан авах ажиллагааны вэб хуудсыг туршилтын журмаар ажиллуулж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэв. Төвлөрлийг сааруулах, шат дамжлагыг цөөрүүлэх үүднээс яам дундын тендерийн хороог татан буулгаж, түүний үүргийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт шилжүүлж, тендерийн сонгон шалгаруулалтыг захиалагч байгууллага өөрөө хариуцан зохион байгуулж, улмаар тендерийн хорооны эрх, үүргийг захиалагч, түүний байгуулсан үнэлгээний хороо гардан хэрэгжүүлж байхаар энэхүү хуулийн төсөлд тусгасан байна.

Монгол Улсын Засгийн газарт БНХАУ-ын Засгийн газраас олгосон буцалтгүй тусламжийн хөрөнгийг ашиглах тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд БНХАУ-ын Засгийн газраас 2004 онд олгосон 50.0 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр трактор, усалгааны тоног төхөөрөмж худалдан авах, түүнийг борлуулсан хөрөнгийг эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай тариалан эрхлэгч нарт дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий зээлийн эргэлтийн сан байгуулж ашиглахыг зөвшөөрсөн.

АХБ, Япон Улсын Засгийн газар, Нордикийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Боловсролын салбарын хөгжлийн 2 дахь төсөл”-ийн хүрээнд Нордикийн хөгжлийн сангаас 3 сая еврогийн зээлийн санхүүжилт авах тухай зээлийн хэлэлцээрт нэмэлт оруулах тухай хуулийг УИХ-аар соёрхон батлуулав.

Монгол Улсын Засгийн газар, Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Техникийн хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн туслалцааны хэлэлцээр”-ийн төслийг УИХ-ын холбогдох байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, хэлэлцээрийг дэмжсэн болно.

Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай УИХ-ын 1998 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад зарим нэмэлт оруулах тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд зарчмын хувьд дэмжиж, ийнхүү хориглох барааны жагсаалтад хаягдал хар ба өнгөт төмөрлөгийн төрлийн бүлэг барааг нэмж оруулахаар тогтсон. Үүнтэй холбогдуулан Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон Тогтоолд өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэв.

Татварын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, багц төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. Татварын тогтолцоог шинэчлэх агуулга бүхий эдгээр хуулиуд батлагдсанаар татварын баазыг өргөтгөх, татвар хураах үйл ажиллагааг сайжруулах, татвар төлөгчдийн эрхийг нэмэгдүүлэх, татварын ачааллыг бууруулах, татварын байгууллагаас татвар төлөгчдөд үзүүлж байгаа үйлчилгээ, чиг үүргийг тодорхой болгох, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг багасгах эрхзүйн орчин бүрдэх юм.

Нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн татвараас чөлөөлөх барааны жагсаалтад нэмэлт оруулах тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд холболтын төмөр буюу ган хоолой, бэхэлгээний ба халалтаас хамгаалах хэрэгсэл, бойлерийн эд

анги, ууршуулагч, шатаагч зэрэг 39 нэр төрлийн барааг жагсаалтад нэмж оруулахаар шийдвэрлэв. Ийнхүү Засгийн газрын 2004 оны 155 дугаар тогтоолоор баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн татвараас чөлөөлөгдөх хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, сав, тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоноглолын жагсаалтад зарим нэмэлт оруулснаар нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн татвараас чөлөөлөгдөх барааны нэр төрөл 101-д хүрэв.

Улс орны ойн нөөц хомсдолд орсон, ойг нөхөн сэргээх өртөг, зардал өссөн, түүнчлэн мод, модон бүтээгдэхүүний зах зээлийн үнэ, өртөг, мөнгөний ханш өөрчлөгдсөнтэй холбогдуулан Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, тогтоол гаргахаар шийдвэрлэлээ. Энэ тогтоолоор эмзэг бүлгийнхний эрх ашигт нийцүүлэн иргэн, байгууллага ой цэвэрлэгээний журмаар модны үзүүр, мөчир, гишүү түүж бэлтгэсэн бол төлбөрийг 70 хувь, түлээнд зориулан хожуул, унангийг бэлтгэсэн бол төлбөрийг 40-60 хувь хөнгөлж байхаар зөвшөөрсөн байна. Мод бэлтгэлийн төлбөрийг шинэчилснээр улсын төсөвт орох ойн нөөц ашигласны орлого жилд дунджаар 600-700 сая төгрөгөөр нэмэгдэх болно.

Улсын гаалийн ерөнхий газрын өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлав. Ингэснээр Монгол Улс, БНХАУ-ын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж байгаа Замын-Үүд дэх чингэлэг шалгах рентген төхөөрөмжийн барилгын гадна зам, талбай, инженерийн шугамын ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, олон улсын гэрээ, хэлэлцээрээр Монголын талын хүлээсэн үүргийг биелүүлэх боломжтой боллоо.

ОУВС, Дэлхийн банкны ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, тэдэнд эдийн засгийн өсөлт, төлбөрийн тэнцэл, экспорт, импорт, хэрэглээний үнийн индексийн талаарх мэдээллийг танилцуулав. Өнгөрсөн 2004 оны гүйцэтгэл болон эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2005-2008 оны төсөөллийн тооцооны үндэслэлийг зарчмын хувьд тохиролцсон болно.

Монгол Улсын 2006 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2007-2008 оны төсвийн орлогын төсөөллийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж байна. Олон хүүхэдтэйн тэтгэмжид амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой 1-2 хүүхэдтэй өрхийг хамруулах, түүнчлэн тэтгэврийн зөрүүг арилгахтай холбогдуулан Монгол Улсын 2006 оны төсвийн хүрээний мэдэгдэлд зардлын тооцоог тодотгон тусгав. Мөн улсын төсвийн хөрөнгөөр 2006 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийн хүрээний мэдэгдлийг УИХ-ын нэгдсэн хуралдаан, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар тус тус хэлэлцүүлэв. Төсвийн хүрээний мэдэгдлийн төслөөр ирэх 2006 онд төсвийн хөрөнгө оруулалт 75.4 тэрбум төгрөгт хүрч, 2005 оныхоос 15.5 тэрбум төгрөгөөр буюу 25.8 хувиар нэмэгдэх төлөвтэй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2005 оны 5 дугаар сарын гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн нийт орлого **271.5** тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 16.4 тэрбум төгрөгөөр буюу 6.4 хувиар давж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 22.8 тэрбум төгрөгөөр буюу 9.2 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага **329.6** тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн нийт зарлагын 81.4 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 18.4 тэрбум төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна. Нэгдсэн төсвийн урсгал тэнцэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.0 тэрбум төгрөгөөр сайжирсан дүнтэй гарсан байна.

Улсын хэмжээнд 2005 оны 6 дугаар сарын 1-ний байдлаар нийт авлага **5.9** тэрбум, нийт өглөг **5.76** тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан дүн мэдээтэй байна.

Улсын төсвөөс 1110 төсөвт байгууллагад 2005 оны 6 дугаар сард **30.3** тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийснээс халамжийн тэтгэвэрт 1.9 тэрбум төгрөг, тэтгэврийн нөхөн олговорт 93.9 сая төгрөг, тэтгэврийн даатгалын санд 3.7 тэрбум төгрөг, олон хүүхэдтэйн тэтгэмжид 977.0 сая төгрөг, төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын хураамжид 404.5 сая төгрөг, эрчим хүчний алдагдлын зөрүүд 205,0 сая төгрөгийг тус тус олгосон байна. Засгийн газрын нөөц хөрөнгөөс 124.9 сая төгрөг,

хуваарилагдаагүй зардлаас 189.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Орон нутагт эхний 6 сард НӨАТ-ын буцаан олголтоор 5.7 тэрбум төгрөг, санхүүгийн дэмжлэгээр 4.1 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна.

Засгийн газар 2005 оны эхний 6 сарын байдлаар **35.1** тэрбум төгрөгийн зээлийг шинээр нэмж ашигласан дүнтэй гарлаа. Засгийн газар эхний 6 сард (өссөн дүнгээр) гадаад зээлийн үндсэн төлбөрт 9.1 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 7.9 тэрбум төгрөг, нийт **17.0** тэрбум төгрөг төлсөн байна. Мөн эхний 6 сарын байдлаар Засгийн газрын бондын үндсэн төлбөрт 8.7 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 342.6 сая төгрөг, бүгд **8.73** тэрбум төгрөг төлсөн байна. Засгийн газрын өрийн бичгийн (өссөн дүнгээр) үндсэн төлбөрт 14.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 186,6 сая төгрөг, бүгд **14.2** тэрбум төгрөг төлсөн байна.

Арилжааны банкуудаас дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу эхний 6 сарын байдлаар (өссөн дүнгээр) зээлийн үндсэн төлбөрт 4.5 тэрбум, хүүгийн төлбөрт 4.2 тэрбум, бүгд **8.7** тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авсан байна. Төрийн сангийн төгрөгийн болон гадаад валютын чөлөөт эх үүсвэрээс 2005 оны эхний 6 сарын байдлаар шөнийн (овернайт) зээл олгож, түүнчлэн Монголбанк болон арилжааны банкуудад богино хугацаат мөнгөн хадгаламжийг байршуулснаар нийтдээ төрийн санд **141.8** сая төгрөгийн хүүгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу Замын-Үүд, Эрээний хоорондын 5 км авто замыг барихтай холбогдуулан хилийн бүсэд гадаадын иргэдийг ажиллуулах, түр гарц нээх, замын барилгын талбайг чөлөөлөх зэрэг багц асуудлыг шийдвэрлэв. Үүний дүнд Замын-Үүд, Эрээний хоорондын авто зам барих ажил эхлээд байна. Хоёр улсын хилийн боомтыг холбосон хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулснаар зорчигч, ачаа эргэлт түргэсэх, зорчин явагчдын ая тухтай байдал сайжрах, цаг хугацаа хэмнэх, тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа уртсах сайн талтай юм.

Япон Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлэх Жижиг, дунд аж ахуйн нэгжийг дэмжих хоёр үе шаттай зээлийн төслийг боловсруулах судалгааны баг болон Японы Олон улсын хамтын ажиллагааны банк (JBIC)-ны ажлын хэсгийн гишүүдтэй ажиллаж, Протокол байгуулсан. Хархорин, Хөшөө цайдмын хооронд авто зам (Билэг Хааны зам) барих тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээрт хоёр тал гарын үсэг зурсан.

ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА

Говийн хөгжлийн санаачлага төслийн Шинжээчдийн багийг бүрдүүлэн, өргөтгөсөн хуралдаан, гадаадын томоохон компаниудын танилцах уулзалтыг зохион байгуулав. Мөн говийн хөгжлийн санаачилга төслийн ажлын хэсгийг өргөтгөн, анхны хуралдааныг зохион байгуулав.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр боловсруулах асуудлаар бизнес эрхлэгчдийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Монгол-Америкийн Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн Монголын талын ажлын хэсэг хуралдаж, хамтарсан зөвлөлийн анхдугаар хуралдааныг зохион байгууллаа.

Туркийн олон улсын хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгчийн газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар Турк Улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийг УИХ-аар соёрхон батлууллаа. Турк Улсаас хөнгөлөлттэй зээл авах асуудлаар хэлэлцээр хийж, арьс ширний цогцолбор байгуулах чиглэлээр Протоколд гарын үсэг зурав.

“Монголын мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөл” ТББ-ын анхдугаар чуулган зохион байгуулж, зөвлөлийн дүрмийг хэлэлцэн баталлаа.

“ЖДҮ-ийг дэмжих хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан хэлэлцүүлэг хийх хуваарь, төсвийг эцэслэн гаргаж, уг хуваарийн дагуу Улаанбаатар хот, Баян-Өлгий, Ховд, Хэнтий, Орхон, Дархан-Уул аймагт зохион явуулж байна.

Олон улсын GMP эмийн үйлдвэрт тавих хяналт, үйлдвэрлэлийн журмын стандартын шаардлага хангасан “АЙВИКО” ХХК-ий тарилгын шингэн үйлдвэрлэх технологийн тоног төхөөрөмжийг импортын гаалийн татвараас чөлөөлөх талаар холбогдох арга хэмжээ авч байна.

Олон улсын байгууллагын “Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл” хөтөлбөрийн сургагч багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулав.

ОХУ-тай худалдааг либералчлах ажлын хэсгийн IV хурлын шийдвэрийн явцыг танилцуулж, ээлжит V хуралд манай талын баримтлах чиглэл, удирдамж, Япон Улсад зохион байгуулах ЭКСПО-2005 дэлхийн үзэсгэлэнд оролцох бэлтгэлийг хангах болон зардлын асуудал, Чех Улсын Үйлдвэр худалдааны сайдын айлчлалын үр дүн, Казахстаны Балхашмыс үйлдвэрт нийлүүлсэн зэсийн баяжмалын авлагын асуудлаар хэлэлцээ хийх, ажлын хэсгийг шинэчлэх, хэлэлцээнд баримтлах удирдамж зэргийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Дэлхийн банкны Төлөөлөгчийн газартай хамтран “Монгол Улс - Чөлөөт худалдааны хэлбэр” сэдвээр видео конференц зохион байгуулж, Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулахад анхаарах асуудлаар Австрали, АНУ, Сингапурын шинжээчдээс зөвлөгөө авч, санал солилцов.

Оёмол, сүлжмэлийн үйлдвэрийн салбарын ажил олгогчоос төлдөг нийгмийн даатгалын хувь, хэмжээг бууруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн батлав. Оёмол, сүлжмэлийн үйлдвэрүүдэд хэрэглэгддэг үйлдвэрлэлийн зориулалттай түүхий эд, сэлбэг хэрэгсэл, үндсэн ба туслах материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулав.

Женев хотноо болсон Монгол Улсын худалдааны бодлогыг ДХБ-д хянан хэлэлцүүлгийн үеэр Монгол Улс ДХБ-д элсэж орсноос хойш эдийн засгийн хөгжилд гарсан үр дүн, хүлээсэн үүрэг амлалтын биелэлтийн явц, үндэсний хууль, тогтоомжийг ДХБ-ын зарчимд нийцүүлэх асуудал, гадаадын хөрөнгө оруулалт, худалдааг өргөжүүлэх талаар баримталж буй бодлого, олон талт худалдааны ДОХА-гийн үе шатны хэлэлцээнд баримталж буй байр суурь, далайд гарцгүй, жижиг, эмзэг эдийн засагтай орнуудын худалдаанд тулгарч буй саад бэрхшээлүүдийн талаар мэдээлэл хийлээ. ДХБ-аас Монгол Улсын худалдааны нээлттэй бодлогын үр дүнд гарсан эдийн засгийн хөгжлийн өсөлтийг сайшаан тэмдэглэж, үүрэг амлалтаа амжилттай биелүүлж байна гэж дүгнэлээ.

ҮХ-ний сайд С.Батболд ИБУИНВУ-д ажлын айлчлал хийж, Монгол-Британийн Бизнесийн уулзалт, дугуй ширээний VIII уулзалтад оролцов. Тэрээр Монгол Улсын бараа бүтээгдэхүүнийг ЕХ болон түүний дотор Британид гаальгүй оруулах боломж нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхай, эрдэс баялгийн үйлдвэрлэл, санхүүгийн үйлчилгээ, ноос ноолуурын салбарт хамтран ажиллах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжтойг дурдсан. Мөн Европын Сэргээн босголт, хөгжлийн банкны удирдлагууд Монгол Улстай дунд хугацааны стратегийн баримт бичгийг боловсруулах, өөрийн салбарыг Монголд байгуулах бодолтой байгаагаа мэдээлж, Монгол Улсын эрдэс түүхий эдийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх стратегийг хамтран боловсруулахын чухлыг тэмдэглэв.

Монгол-Европын Холбооны хамтарсан хорооны VIII хуралдаан болон худалдаа хөрөнгө оруулалтын дэд хорооны III хуралдаан боллоо. Манай улс хөгжиж байгаа орны хувьд ЕХ-ны худалдааны хөнгөлөлтийн системд хамрагдаж, зохих хөнгөлөлтийн журмаа шинэчлэх гэж байна. Энэхүү журмын дагуу тодорхой болзол, шалгууруудыг хангасан хөгжиж байгаа орнуудад нэмэлт хөнгөлөлт үзүүлж, Европын нэгдсэн зах зээлд хөнгөлөлтөд хамрагдсан бараа бүтээгдэхүүнийг гаалийн татваргүйгээр нэвтрүүлэх өргөн боломжтой болох юм. Мөн ЕХ-ны санхүүжилтээр 200 сая еврогийн 2 төсөл хэрэгжүүлэхээр тохиров.

“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. “Замын-Үүд” эдийн засгийн

чөлөөт бүсийг 2004-2006, 2006-2010, 2010-2015 он гэсэн 3 үе шаттайгаар хөгжүүлэх мастер төлөвлөгөө болон Ерөнхий төлөвлөгөө боловсруулан, тэнд нийт 10 орчим тэрбум ам.долларын хөрөнгө оруулах юм. 2005-2006 онд 600 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөөд байна. “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, мастер төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, цаашид хийх ажлын чиглэлийг гаргаад байна.

Жижиг, дунд үйлдвэр /ЖДҮ/-ийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Чөлөөт худалдааны гэрээ байгуулах Road Map боловсруулах ажлын чиглэлээр худалдааны гол түнш орнуудаар бараа болон үйлчилгээний тарифын судалгаа хийж, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулснаар манай орны эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үр ашгийг тооцоолж байна.

ЖДҮ эрхлэгчид, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хүндрэл, бэрхшээл учруулж буй хууль тогтоомжийн судалгаа гаргаж, нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулав. 2004-2006 онд хэрэгжүүлэх ЖДҮ-ийг дэмжих төслийн гэрээнд гарын үсэг зурлаа.

Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн шавыг тавилаа.

Дэлхийн худалдааны байгууллагатай хамтран Үйлчилгээний худалдааны асуудлаар 2 өдрийн үндэсний семинар зохион байгуулав.

“Зарим бараанд ногдуулах экспортын татварын хувь хэмжээ тогтоох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

Ховд аймагт зохион байгуулагдсан Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрийг хэлэлцэх улсын зөвлөгөөнд оролцож, “Баруун бүсийн үйлдвэр, худалдааны тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам” илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийн асуудлаар орон нутгийн болон Улаанбаатар хотын модны үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн удирдах ажилтнуудын уулзалт, семинарыг зохион байгууллаа.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн эксперт, Английн бие даасан эксперт нарыг урьж ирүүлэн Монгол Улсын уул уурхайн салбарын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийлгүүлэн, зөвлөмж гаргуулан “Монголын Уул уурхайн салбарын өрсөлдөх чадвар” сэдэвт семинарыг зохион байгуулав.

Монполимет ХХК-ийн Тосонгийн гольдрол дээр угсарсан хөвөгч угаах төхөөрөмж, “Би Эйч Эм” ХХК-ийн Тавтын алтны үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах комисс байгуулан, Тосонгийн гольдрол дээр угсарч суурилуулсан хөвөгч угаах төхөөрөмж 250 ДМ-ийг ашиглалтад хүлээн авлаа.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, УИХ-ын нэгдсэн хуралдааны эхний хэлэлцүүлэгт оруулж хэлэлцүүлэв.

Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг 2006 онд зохион байгуулах, ОХУ-тай хийж буй хэлэлцээнүүдийн явц, Монгол-Оросын Засгийн газар хоорондын Комиссын ээлжит хуралдаанд баримтлах чиглэл, удирдамж, төлөөлөгчдийн бүрэлдэхүүн зэрэг асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэв.

Германы Сименс корпорацийн дэд Ерөнхийлөгчийн манай улсад хийсэн айлчлалын үеэр тус корпораци, Үйлдвэр худалдааны яам хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН

Боловсролын талаар:

Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газар, их, дээд сургуулийн багш, иргэдийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн ажилтнууд оролцсон “Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй” нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Зайны сургалтын сүлжээгээр

холбогдон зохион байгуулж буй энэхүү нээлттэй хэлэлцүүлгээр хоёр долоо хоног тутам тодорхой асуудлыг сонгон авч хэлэлцэн зохистой шийдэл гаргах үндэслэл, баримтлалыг тодорхойлохыг зорьж байгаа юм.

2005-2006 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн сурагчийн дүрэмт хувцсыг эцэг эхийн 50-иас доошгүй хувийн санал авсан загварыг сонгохыг нийт сургуулиудын захирлуудад даалгалаа.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах нь” сургалтын модулыг боловсруулан Архангай, Хөвсгөл, Улаанбаатарын 200 гаруй багш нарт хүргэсний зэрэгцээ “Боловсролын хүртээмж”, “Тэгш хамруулан сургах нь” гарын авлагыг Хүүхдийг ивээх сан /Англи/-ийн дэмжлэгтэйгээр хэвлүүлэн багш нарт хүргэлээ.

“Монгол-Британийн дугуй ширээний уулзалт”-д төлөөлөгч оролцон, Монгол Улсын Засгийн газраас боловсролын талаар баримталж байгаа бодлого, англи хэлний сургалтыг өргөжүүлэх, хоёр дахь хэл болгох, латин үсгийн үндэсний хөтөлбөр болон латин үсгийн стандартыг хэрэгжүүлэх талаар зохиож байгаа ажлын тухай мэдээлж, энэ чиглэлээр хамтран ажиллах санал тавив. Уулзалтын үеэр Британий Гадаад хэрэг, хамтын нөхөрлөлийн яамны дэд сайд боловсролын салбарт тодорхой туслалцаа үзүүлэх, Монгол Улс дахь англи хэлний сургалтын төвүүдийг бэхжүүлэн өргөтгөх, латин үсгийн стандартыг боловсронгуй болгох талаар хамтран ажиллаж, туслалцаа үзүүлэхээ албан ёсоор мэдэгдсэн юм.

“Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого” баримт бичгийг баталлаа. Энэхүү цогц бодлого нь бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээг эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа, нийгмийн халамж хамгаалал, боловсрол гэсэн харилцан уялдаа бүхий цогц асуудлын хүрээнд хэрэгцээ, эрэлт, түүний хангалт нийлүүлэлтийг оновчтой хангах нөхцөлийг бүрдүүлэх замаар хүний болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн ирээдүйн өсөлтийг дэмжихэд чиглэгдсэн бүх талын хөрөнгө оруулалтыг үр дүнтэйгээр нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр хийгдсэн “Бага боловсролын сурлагын амжилтын судалгаа” төслийн урьдчилсан тайланг гаргалаа. Бангкок хотноо болсон “Ази болон Номхон далайн бүсийн орнуудын бага боловсролын сурлагын амжилтын хяналт-шинжилгээний судалгааны төслийн техникийн II хуралдаанд монголын судалгааны тайланг хэлэлцүүлж, бүс нутгийн хэмжээнд хамгийн сайн хийсэн орноор шалгарсан.

2005-2006 оны хичээлийн жилээс хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын их, дээд сургуульд 50 оюутан, 50 мэргэжил дээшлүүлэгчид, БНЧУ-ын Засгийн газрын тэтгэлгээр Чех улсад 4 хүн докторантурт суралцах болов. ОХУ, Украин, Казахстан улсын их, дээд сургуульд хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 2005-2006 оны хичээлийн жилээс суралцах оюутан, магистрант, докторант нарын уралдаант шалгалтыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж, шалгалтыг 3 үе шаттайгаар зохион байгуулав.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжиж буй “Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэг” төслийн хүрээнд 2005-2006 оны хичээлийн жилээс тус улсын их, дээд сургуулийн магистрантурт 20 хүн суралцахаар гэрээ байгуулав.

“Дэвшилтэт технологитой үйлдвэрлэл ба өндөр зэрэглэлийн мэргэжлийн сургалт” сэдэвт семинар-ярилцлагыг зохион байгуулав. Энэ семинар-ярилцлагын үр дүнд мэргэжлийн боловсрол, сургалтын чиглэлээр Япон Улсад тавих төслийн чиглэл тодорхойлогдох боломж бүрдэж байгаагаараа ач холбогдолтой юм.

Оршин суугаа газраасаа 500 км ба түүнээс дээш километр хол сургуульд суралцагч оюутныг өвлийн амралтаар орон нутагтаа зорчих нэг талын зардлыг төрөөс хариуцан олгодог болсны дагуу Улаанбаатар хотоос алслагдсан байдал /550 км /-аар болон Орхон, Архангай, Ховд аймагт сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа их сургууль, дээд сургууль, коллежид оршин суудаг газраасаа өөр аймгаас элсэн суралцаж байгаа оюутанд өвлийн амралтаараа ирэх, буцах зардлын нэг талыг төрөөс хариуцах төсвийн тооцоог хийж зарим сургуулиудын санхүүжилтийг олгож эхэллээ.

2005-2006 оны хичээлийн жилд төрийн өмчийн 10 сургуульд 16 мэргэжлээр, төрийн бус өмчийн 26 сургуульд 31 мэргэжлээр бакалаврын, 4 сургуульд магистрын, 6

мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд 8 мэргэжлээр тус тус сургалт эрхлэх зөвшөөрөл олголоо.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч, хатагтай У И-гийн манайд хийсэн айлчлалын үеэр “БНХАУ-д Монгол оюутан суралцуулах болон МУ-д хятад хэлний багш ажиллуулах тухай БСШУЯ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулав.

Төрийн болон төрийн бус өмчийн бүх ерөнхий боловсролын сургуулиудад төгсөлтийн шалгалтыг сургуулиуд бие даан зохион байгуулсан бөгөөд шалгалтын явцыг нийслэлийн Багануур, Налайх дүүрэг, Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр сумдад үзэж танилцав. Энэ онд улсын хэмжээгээр 8 дугаар ангийн 56.0 мянга, 10 дугаар ангийг өдрөөр 37.0 мянган суралцагч төгслөө.

Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд боловсролын үнэмлэх, гэрчилгээ олгох ажлыг ёслол төгөлдөр тэмдэглэж байх зорилгоор “Төгсөлтийн ёслолын арга хэмжээг зохион байгуулах тухай” БСШУ-ы сайдын тушаал гаргалаа. Энэхүү тушаалын дагуу ерөнхий боловсролын сургуулийн 8, 10 дугаар анги төгсөгчдөд боловсролын үнэмлэх, гэрчилгээг 6 дугаар сарын 18-ны өдөр олгох ажлыг зохион байгуулж, уг арга хэмжээг цаашид жил бүр уламжлал болгох, сургууль төгсөгчдийн холбоо байгуулах, түүгээр дамжуулан төгсөгчдөөс сургуулиа хөгжүүлэх ажлыг зохион байгуулах юм.

“Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг горилсон багш нарын материалд дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулан 20 багшид “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг олгож, эдгээр багш нарт олгох мэргэжлийн зэргийн нэмэгдлийн хувь хэмжээг тогтоолоо.

Боловсролын мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд “Монголын дээд боловсролын өнөөгийн байдал, цаашдын стратегийн чиглэлүүдийн тойм”-ыг дээд боловсролын сургалтын байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлэв.

Соёл, урлагийн талаар:

“Морин хуур, уртын дуу” үндэсний хөтөлбөр батлан, хэрэгжүүлж байна.

“Ном хэвлэлийн шилдэг бүтээлийг худалдан авах журам”-ын дагуу ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг шинэчлэн үнэлгээ өгөх, улсын санд худалдан авах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг баталж, “Шилдэг ном”-ыг шалгаруулав.

Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг дэлхийн өвд бүртгэсэн батламж бичиг гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулав.

Үндэсний мэдээллийн хангамжийг сайжруулах нь” сэдэвт олон улсын номын санчдын зөвлөгөөнийг АНУ-ын Элчин сайдын яам, Америкийн Монгол судлалын төв, Азийн сан, Монгол дахь ЮНЕСКО-гийн Үндэсний комисс зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

БНХАУ-д “Монголын соёлын өдрүүд”-ийг зохион байгуулав. Анх удаа зохион байгуулсан манай соёлын өдрүүд нь Монголын ард түмний соёлын өв уртын дуу, хөөмий, морин хуур, уран нугаралт, ардын биелгээ болон сонгодог дуурь, бүжгийн жүжгийн дээжсийг Хятадын ард түмэнд танилцуулан, өнөөгийн Монгол орны соёл, урлагийн хөгжлийн шинэ хандлага, уран сайхны сэтгэлгээний олон талт хэв маягийг харуулсан орчин үеийн дүрслэх урлагийн шилдэг бүтээлүүдийг болон монголын ард түмний амьдрал, зан заншил, үзэсгэлэнт байгаль, монгол орны бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлтийн гэрэл зургийн үзэсгэлэнг дэлгэн үзүүлсэн.

“Түүх, соёлын дурсгалт зүйлд зэрэглэл, үнэлгээг тодорхойлох мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн, хурлыг зохион байгуулж, Дүрслэх урлагийн музей, Богд хааны ордон музей, Эрдэнэ зуу музейд хадгалагдаж байгаа 38 танка буюу бурхны шүтээн зураг, Төвхөн хийдэд хадгалагдаж буй Өндөр гэгээн Занабазарын бүтээсэн өөрийнх нь Лагшин дүр зэргийг газар дээр нь үзэж хэмжин тодорхойлолтыг гарган “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл”-ээр тодорхойлов. Соён гэгээрүүлэгч Г.Занабазарын мэндэлсний 370 жилийн ойг 7 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Хархоринд тэмдэглэхээр шийдвэрлэв.

Монгол Улсын БСШУЯ, ХБНГУ-ын урлаг, үзэсгэлэнгийн цогцолборын хооронд 2001 онд байгуулсан гэрээний дагуу Тулгар төр байгуулагдсны 800 жилийн ойд зориулж “Чингис хаан ба түүний өв залгамжлагчид” үзэсгэлэнг ХБНГУ-ын Бонн хотноо 3 сарын хугацаатайгаар энэ оны 6 дугаар сард нээлээ. Энэхүү үзэсгэлэнд Монгол улсын бүх музейнүүд, тухайлбал, Үндэсний түүхийн музей, Дүрслэх урлагийн музей, Эрдэнэзуу музей, Монгол цэргийн музей, Археологийн хүрээлэн, Үндэсний номын сан зэргээс 400 гаруй үзмэр оролцож байна. Үзэсгэлэнд археологийн хүрээлэн, Бонны их сургуультай хамтран 1999 оноос эхлэн хэрэгжүүлж буй Хархорумын туурийн археологийн малтлагаас олдсон эд өлгийн зүйлүүд болон Турк-Монголын археологичдын Хөшөө цайдам дахь Билгэ хааны малтлагаас олдсон алт, мөнгөн эдлэлүүдийг дэлхийд анх удаа үзмэрт тавьж дэлгэн үзүүлсэн болон 20-оод улсын дэлхийд алдартай музейнүүдээс монголын түүх, соёлтой холбоотой 200 гаруй үзмэр дэлгэн үзүүлснээрээ онцлог боллоо.

“Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэмэлт оруулах тухай” асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, түүх, соёлын 39 хосгүй үнэт дурсгалт зүйлийг жагсаалтад шинээр нэмж оруулан батлуулав.

“Соёл, урлагийн ажилтны мэргэшил дээшлүүлэх, сургалт зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын дагуу бүжигчдийн мэргэшил дээшлүүлэх сургалтыг 21 хоногийн хугацаатайгаар Хөгжим, бүжгийн коллеж дээр зохион байгуулж байна. Сургалтад Хэнтий, Өмнөговь, Увс, Говь-Алтай аймгийн Хөгжимт драмын театрын бүжигчид хамрагдаж байгаа юм. Түүнчлэн орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагуудын удирдлагуудыг Удирдлагын академид 3 сарын сургалтад хамруулсны гадна Өвөрхангай аймгийн номын санчдад зориулан “Электрон каталоги” сургалт зохион байгуулж, 15 суманд ЮНЕСКО-гийн CDS-ISIS программ/ электрон каталоги зохион байгуулах ажлыг эхлүүллээ.

Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт 2004-2006 онд хамтран ажиллах гэрээний дагуу Иркутск хотын хүүхэд, залуучуудын театрын айлчлан тоглолтыг Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

Шинжлэх ухаан, технологийн талаар:

“Монгол Улсын нутагт археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам” батлан хэрэгжүүлж эхлэв.

Монгол Улсын үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн үндэсний инновацийн бодлого, стратегийн төсөл боловсруулж байна.

БСШУ-ы сайд П.Цагаан тэргүүтэй төлөөлөгчид Япон Улсад айлчлав. Уг айлчлал нь хоёр орны боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны шинэ хандлагыг тодорхойлох, цаашдын хөгжилд ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

БСШУЯ, АНУ-ын Азийн Сангийн хооронд “Номын өргөө” байгуулах асуудлаар хамтран ажиллах “Ойлголцол”-ын санамж бичигт хоёр тал гарын үсэг зурлаа.

Эрдэм шинжилгээний байгууллагаас боловсруулан үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн болон нэвтрүүлэхэд бэлэн болгосон үр дүнгийн судалгаа хийж байна. Энэ нь улсын захиалгаар хийгдсэн судалгааны ажлын үр дүнгээс үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжтойг нь сонгож бизнесийнхэнтэй хамтран жижиг, дунд үйлдвэр байгуулахад ач холбогдлоо өгнө.

“Монгол Улсын Үндэсний хөгжлийн хөтөлбөр–2021”-ийн төслийн талаар зайны сургалтын сүлжээ ашиглан нээлттэй хэлэлцүүлгийг төрийн ба төрийн бус байгууллага, улс төрийн намууд, иргэний нийгмийн төлөөллийн оролцоотой зохион байгуулав.

Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулав. “Шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа” сэдэвт уулзалт, үзэсгэлэнг зохион байгуулав. Уулзалт, үзэсгэлэнд ЭШБ-уудаас сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн төсөл, судалгааны ажлын үр дүнгээс үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжтой 150 гаруй бүтээлийг харуулав.

Бизнесийн салбарыг төлөөлж 120 гаруй байгууллагын төлөөлөл оролцож зарим эрдэм шинжилгээний хүрээлэн, компаний хооронд тогтвортой хамтын ажиллагааны гэрээ байгуулав.

Монгол Улсын БСШУ-ы сайд П.Цагаан тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Монголын соёлын өдрийн нээлтэд оролцож, БНХАУ-ын Боловсролын яам, Соёлын яамны сайд, ШУТ-ийн яамны дэд сайдтай уулзаж, хоёр орны боловсрол, соёл, шинжлэх ухааны харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын үйл ажиллагааны талаар санал солилцсон нь хоёр орны салбарын хамтын ажиллагааны хөгжилд чухал хувь нэмэр оруулав.

“Төрөөс баримтлах хэлний бодлогын асуудлууд” эрдэм шинжилгээний бага хурлыг Шинжлэх ухааны академи, Хүмүүнлэгийн ухааны их сургуультай хамтран зохион байгуулав. Энэхүү хуралд 60 гаруй эрдэмтэн судлаачид оролцож, илтгэл тавьж хэлэлцүүлэн цаашид хийх ажлын чиглэлээр зөвлөмж гаргалаа.

“Баруун бүсийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэлэлцсэн бүсийн зөвлөгөөнийг Ховд аймагт зохион байгуулж, “Баруун бүс нутгийн боловсролын тулгамдсан асуудал, цаашид авах арга хэмжээ” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв.

ЭРҮҮЛ МЭНД

“Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг сайжруулахад мэдээлэл, харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх нь” техник туслалцааны төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг сайжруулахад мэдээлэл, харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх нь” техник туслалцааны төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг баталж, үйл ажиллагааг эхлүүлэв.

Эмнэлгийн тусламжийг удирдах газрыг Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв болгон зохион байгуулсан. Мөн Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны штаб, удирдлагын бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарийг баталлаа.

Эрүүл мэндийн удирдах ажилтны зөвлөгөөнийг “Удирдлагын арга барилыг шинэчилье” сэдвээр зохион байгууллаа.

“Эмгэг судлалын төв”-ийг байгуулж, төвийн дүрэм, орон тоо, бүтцийг батлан, үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Алсын түргэн тусламжийн үйл ажиллагааг эхлэн гэрээгээр гүйцэтгүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газарт даалгасан. Алсын түргэн тусламжийн үйлчилгээг зохицуулах журам, алсын дуудлагаар үйлчлэх өвчний жагсаалт, эмч томилсон тухай маягт, дуудлагын хуудас, клиникийн эмнэлэг, төрөлжсөн нарийн мэргэжлийн төвүүдийн алсын түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх чиглэлийг батлав.

“Эхийн эндэгдлийг бууруулах стратеги”-ийг баталж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг орон нутгийн онцлогт тохируулан боловсруулах ажлыг хийж байна.

Эрүүл мэндийн яамны дэргэд Шинжлэх ухаан, технологийн орон тооны бус зөвлөл ажиллуулахаар шийдвэрлэн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг баталж, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг ашиглах, шинэ техник, технологийг нэвтрүүлэх цар хүрээг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийг сайжруулахад анхаарч ажиллахаар болов.

Дэлхийн эрүүл мэндийн өдрийг тохиолдуулан “Эх, хүүхэд бүрийг эрхэмлэн хайрлая” уриаг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг дарга нарт “Эх, хүүхдэд ээлтэй аймгийн тэргүүний Засаг дарга” шалгаруулах нэг жилийн аяны болзлыг баталж, орон нутагт “Дэлхийн эрүүл мэндийн өдөр”-ийг тэмдэглэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна.

“Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нэгдсэн төсөвт тусгаж, гадаад дотоодын болон хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтыг татан оролцуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахаар болов.

Олимпийн наадамд бэлтгэх үндэсний хороо, бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулав. “Спортод сэргээшийн эсрэг Копенгагений Тунхаглал”-д Монгол Улс нэгдэн орохоор боллоо.

“Эх, хүүхдийг бичил тэжээлийн дутлаас сэргийлэх стратеги”-ийг баталж, энэхүү стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлуулж, хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж байх, стратегийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн IV улиралд Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн хуралд хэлэлцүүлж байхаар боллоо.

Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний хувьсах зардлыг санхүүжүүлэх хэмжээ, амбулаторийн тусламж үйлчилгээний нэг даатгуулагчид ногдох зардлын хэмжээг баталж, мөрдүүлэв.

Сумдад ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдээс цаашид тухайн сумандаа тогтвортой ажиллах мэргэжилтнийг сонгож нэг удаагийн түргэвчилсэн сургалтаар эм найруулагч бэлтгэх журам, суралцагсадтай хийх гэрээний үлгэрчилсэн загварыг баталж, түргэвчилсэн сургалтаар бэлтгэгдсэн эм найруулагчдад зохих журмын дагуу зөвхөн суманд ажиллах эм барих зөвшөөрөл олгож байхаар болов.

Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийг 2005 онд төгсөж байгаа 136 эмчийг хөдөө орон нутагт хуваарилан, төгсөгчдийг орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллуулах, сургалтын төлбөрийг барагдуулахад хяналт тавьж ажиллахаар болов.

Бүсийн оношлогоо, эмчилгээний төвүүдийн төсөв эмч ажилтнуудын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох, барилга байгууламжид их засвар, өргөтгөл хийх, өмчийн харьяалал, бүс нутгийн хүрч үйлчлэх хүрээ, хөрөнгө оруулалтын зардлын асуудлыг судалж, БОЭТ-үүдийн захирлуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, төвүүдийн хүний нөөцийн чадавхи, хангамжийн асуудлыг Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөөнд тусгаж тухайн орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах, БОЭТ-үүдийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, статус, шатлалыг тодорхойлж, бүтэц үйл ажиллагааны стандартыг боловсруулах, БОЭТ-д хийгдэх зарим оношлогоо, эмчилгээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн иргэдтэй хуваалцах, төвүүдэд ашиглагдаж буй зарим тоног төхөөрөмжийг дахин хуваарилах асуудлыг судалж танилцуулахаар боллоо.

Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн нэгтгэлийн программ хангамжийн зардалд зориулж 5980.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн төвлөрсөн арга хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлэх төсвөөс зарцуулахаар шийдвэрлээд байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар:

Манай улсад бэлгийн замаар дамжих халдвар дорвитой буурахгүй байгаа бөгөөд хүний дархлал хомсдлын вирусын халдварын 4 тохиолдол шинээр илэрсэнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл хуралдлаа. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагаанд нийгмийн бүхий л салбарын оролцоог нэмэгдүүлэх талаар тус зөвлөлийн даргын албан даалгавар гаргахаар шийдвэрлэлээ. Уг албан даалгаварт ХДХВ/ДОХ/БЗДХ-ыг илрүүлэх лабораторийн оношлогооны чадавхийг сайжруулах, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, 100 хувь бэлгэвч хэрэглэх хөтөлбөрийг өргөжүүлэн үндэсний түвшинд хэрэгжүүлэх, оюутан сурагчдад зориулсан ХДХВ/ДОХ/БЗДХ-ын талаарх хичээлийн чанарыг сайжруулах, нийт хүн амд зориулсан ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэх талаарх МСС-г эрчимжүүлэх зэрэг асуудлуудыг тусгахаар боллоо.

Зарим аймаг, хотуудад БЗДХ ихэссэнтэй холбоотойгоор ЭМЯ, Глобаль сангийн төслийг зохицуулах нэгж, Халдварт өвчин судлалын үндэсний төв, НҮБ-ын Хүн амын сан, ДОХ-той тэмцэх үндэсний сан зэрэг байгууллагууд хамтран ажлын хэсэг байгууллаа.

Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх зорилгоор БЗДХ ихэссэн Сэлэнгэ аймгийн төв болон зарим сумдад НҮБ-ын Хүн амын сан, ХӨСҮТ, ЭМШУИС, ДОХ-ын үндэсний сангийн мэргэжилтнүүдийн баг хамтран “Хамтдаа сэргийлье” сэдэвт компанит ажлыг зохион байгуулсан нь үр дүнтэй боллоо.

Дархлаажуулалт бүхий халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Дархлаажуулалтад бүрэн хамруулах, дархлаажуулалтаас хоцорсон хүүхдүүдийг хамруулах талаар үе шаттай арга хэмжээ авч ажиллаж байна.

Шувууны томуу БНХАУ-ын Чинхой мужид гарсантай холбогдуулан Онцгой байдлын газар, Улсын мэргэжлийн хяналтын газар, ХХААЯ-тай хамтран цаашид авах арга хэмжээний чиглэлийг гаргав.

2005 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар Монголэмимпекс компанийн агуулахад 218 нэрийн 1309.2 сая төгрөгийн, орон нутгийн эм хангамжийн компаниудад 86-199 нэрийн 509.3 сая төгрөгийн Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн /ҮЗШЭ/ үлдэгдэлтэй байлаа. ҮЗШЭ-ийн хангамж Улаанбаатар хотод 75.0%, орон нутагт 70-82.0%-тай байна.

Оны эхний 5 сард 18450 эх амаржиж, 18420 амьд хүүхэд төрсөн байна. Энэ хугацаанд 25 эх эндсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 8-аар, сүүлийн 5 жилийн дунджаас 2-оор тус тус нэмэгдсэн байна. 1 хүртэлх насны 444 хүүхэд эндсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс 5-аар, сүүлийн 5 жилийн дунджаас 75 тохиолдлоор буурсан байна. 1-5 хүртэлх насны 107 хүүхэд эндэж өнгөрсөн оны мөн үеийнхээс 7 тохиолдлоор, сүүлийн 5 жилийн дунджаас 43-аар буурсан байна.

2005 оны эхний 5 сард халдварт өвчний 13049 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1089-өөр нэмэгдэж, сүүлийн 5 жилийн дунджаас 747-оор буурч, 10000 хүн амд халдварт өвчний 51.8 тохиолдол ногдох боллоо.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР

Нийгмийн хамгааллын бодлого, зохицуулалтын талаар:

“Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлж эхэлснээр амьжиргааны түвшингээс доогуур орлоготой 0-18 хүртэл насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн хүүхэд бүрт сар бүр 3000 төгрөгийн олон хүүхэдтэйн тэтгэмж олгож байгаа бөгөөд жилд 127.0 мянган өрхийн 560.0 мянга гаруй хүүхэд уг тэтгэмжид хамрагдаж, 21.6 тэрбум төгрөгийг төсвөөс зарцуулах юм.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодоход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн тогтоож, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүллээ. 1990 ба түүнээс өмнөх онуудын хөдөлмөрийн хөлсийг 100 дахин, 1991-2002 онуудын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг 50.0-1.03 дахин нэмэгдүүлэн тооцож, нийт иргэдийн тэтгэврийг шинэчлэн тогтоох юм. Түүнчлэн 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс 1998 оны 7 дугаар сарын 1 хүртэлх хугацааны тэтгэвэр тогтооход баримтлах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг өөрчлөн 120000 төгрөг болгож нэмэгдүүллээ.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг 7.5-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх арга хэмжээг 2005 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна.

“Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэж, эхний тохиролцоонд хүрээд байна. Хэлэлцээрийг байгуулснаар хоёр орны иргэдийг тэтгэврийн даатгалд өөрийн орны хуулийн дагуу хамруулах, тэтгэврийн даатгалын шимтгэлд давхар хамруулахгүй байх, иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах ач холбогдолтой юм. Тухайлбал 2700 гаруй Монгол иргэдийн Солонгос Улсын

тэтгэврийн санд хөдөлмөрийн хөлснөөсөө төлж буй 1.4 тэрбум орчим воны шимтгэлийн төлбөрөөс чөлөөлөгдөх, Солонгосын ажил олгогчоос төлөх 4.5 хувийн шимтгэл зогссоноор Монгол ажиллагсдыг ажилд авах сонирхол нэмэгдэх зэрэг ач холбогдолтой юм.

Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийг 7 дугаар сарын 1-нээс эхлэн 7.5 хувиар нэмэгдүүлж, 42.0 мянган тэтгэвэр авагчдад нийт 272.0 сая төгрөгийг 2005 онд нэмж зарцуулахаар боллоо. Мөн 1945 оны чөлөөлөх дайн, баруун хилийн зэвсэгт тулгаралтад оролцсон нийт 2.8 мянган ахмад дайчдад тус бүр 200.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмж олгохоор шийдвэрлэсэн.

“Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийгмийн халамжийн багц хуулиудтай уялдуулан ахмад настны нийгмийн хамгааллын арга хэмжээг олон улсын жишигт ойртуулан нийгэм хамт олонд түшиглэсэн халамжийн цогц үйлчилгээ хэлбэрээр төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, гэр бүл, иргэдийн хамтын оролцоотойгоор гүйцэтгэх нийгмийн хамгааллын үйлчилгээний эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэл баримтлав. Хуулийн төсөл нь 4 бүлэг, 16 зүйлтэй бөгөөд одоо үйлчилж байгаа хуулийн 12 зүйлийг өөрчлөн найруулж, 1 зүйлийг хасч, шинээр 5 зүйл нэмж оруулсан байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд одоогийн үйлчилж буй хуулийн 23 зүйлийг өөрчлөн найруулж, 4 зүйлийг хасч, шинээр 17 зүйл нэмж оруулав. Уг хуулийн төслийг боловсруулахдаа нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлсон хуулийн заалт, хамрах хүрээг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн НҮБ, ДЭМБ, ОУХБ-ын аргачлалд нийцүүлэх, “Нийгмийн халамжийн тухай”, “Нийгмийн даатгалын тухай” хууль тогтоомжуудтай уялдуулж хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоог идэвхжүүлэх, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээг нийгэм хамт олонд түшиглэсэн цогц үйлчилгээ хэлбэрээр төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, гэр бүл, иргэдийн өөрсдийн оролцоотойгоор гүйцэтгэх нийгмийн хамгааллын эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэл баримталсан болно.

Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав. Хуулиар амьжиргааны түвшингээс доогуур орлоготой 1 ба 2 хүүхэдтэй өрхийн хүүхдэд 2005 оны 6 дугаар сарын 1-нээс сар тутам 3000 төгрөг олгохоор заасан ба уг арга хэмжээнд улсын хэмжээгээр 260.2 мянган хүүхэд хамрагдаж, улсын хэмжээгээр 2005 онд нийт хүүхдийн мөнгө хөтөлбөрт 17.7 тэрбум төгрөг зарцуулах юм.

“Аргачлал батлах тухай” ҮСГ-ын дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар баталсан өрхийн амьжиргааны түвшинг үнэлэх аргачлалын амьжиргааны түвшинг үнэлэх үнэлгээний хүснэгтийг шинэчлэн боловсруулж батлуулав.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, хөдөлмөрийн тусгай нөхцөл тогтоох заавар, жагсаалтыг шинэчлэн боловсруулж, батлуулав. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1998 оны А/250 тушаалд 12 бүлэг 520 заалт байсныг 12 бүлэг 360 заалт болгон цөөрүүлснээр жагсаалтыг 30%, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоолгох хүмүүсийн тоо 25-30%-иар оновчтой болж цөөрөх юм.

Оюутан, суралцагчдын нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлж 80%-д хүргэснээр тэдний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөл бололцоо хангагдаж, нийгмийн даатгалын санд 143,2 сая төгрөгийн даатгалын шимтгэл төвлөрөх боломжтой болох юм.

Хүн амын хөгжлийн бодлого, зохицуулалтын талаар:

Жендэрийн асуудал нь олон талт, салбар дундын шинж чанартайг харгалзан үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Хүйсийн тэгш байдлыг хангах үндэсний зөвлөл”-ийг “Жендэрийн тэгш байдлын хороо” болгон өөрчилж, Ерөнхий сайдаар даргалуулан байгуулсан. Тус хороо жендэрийн тэгш байдлын асуудлаар үндэсний

хэмжээнд зөвлөлдөх байгууллага байх ба энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг нь үнэлэхэд нөлөөлөх, төрийн болон ТББ, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс гаргасан үүсгэл санаачилгыг дэмжих, оролцоог нь хангах, уг асуудлыг бусад салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах зорилготой юм.

АХБ, Дэлхийн банкны тусламж, дэмжлэгтэйгээр “Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн хоёрдугаар шатны төлөвлөгөөний асуудлаар зөвлөлдөх уулзалт”-ыг зохион байгуулан нийт 50 орчим хүнийг оролцуулав. Уулзалтын гол үр дүн нь жендэрийн асуудлаар сүүлийн үед олон улсын байгууллагаас хийсэн үнэлгээ, дүгнэлтийг төрийн бодлого, шийдвэрт хэрхэн тусгаж байгааг харуулсан нь цаашид холбогдох байгууллагын хамтын ажиллагаа улам сайжрах, эн тэргүүний асуудалд төр, олон нийт, хандивлагчдын анхаарлыг чиглүүлэхэд оршиж байлаа.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын мөрдөх үлгэрчилсэн дүрмийг баталлаа. Дүрэмд хүүхдийн асрамж, халамжийн төвд ямар шаардлага тавигдах, төв нь ямар эрх, үүрэг, бүтэц, зохион байгуулалттай байхыг тодорхойлсон бөгөөд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад зөвшөөрөл олгох, цуцлах, үйл ажиллагааных нь хэм хэмжээг тогтоох, хяналт тавих зэрэг харилцааг зохицуулах юм.

Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороог шинэчлэн байгууллаа. Хороо нь Гэр бүлийн хөгжил, Хүүхэд, өсвөр үе, залуучуудын хөгжил, Ахмад настан, насжилт болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх салбар хороод, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэг бүхий Удирдах зөвлөл, шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх зорилготой Шинжээчдийн бүлэгтэйгээр зохион байгуулагдлаа. Мөн нийслэл, аймгуудад орон нутгийн салбар зөвлөлийг байгуулан ажиллуулах юм.

“Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар” сэдэвт судалгаа хийлээ. Судалгаанд АНУ, Солонгос, Чех улсуудад ажиллаж байгаа 700 гаруй иргэд, гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь гадаадад ажиллаж байгаад ирсэн 216 өрх, 184 иргэнийг хамруулсан байна. Судалгаагаар гадаад орнуудад ажиллаж байгаа монгол иргэдийн хөдөлмөрийн нөхцөл, тулгамдаж буй асуудал, гэр орондоо үзүүлж буй дэмжлэгийн талаар судалж, дүгнэлт гаргаснаараа шинэлэг боллоо.

Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан залуучуудыг харилцан солилцож айлчлуулах хөтөлбөрийн дагуу танилцах аяллыг зохион байгуулав. Хөтөлбөрийн дагуу монголын залуучуудын төлөөлөгчид БНСУ-д айлчилж, БНСУ-ын Соёл, аялал жуулчлалын яам болон тус улсын залуучуудын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцлаа.

“Хотжилт ба бага орлоготой иргэдийн орон сууцны хэрэгцээ” үндэсний хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлгээр бага орлоготой иргэдийн орон байраар хангагдах эрх, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, орон байрны хэрэгцээ, хангамжийг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй хямд төсөр орон сууцны материал, санхүүжилт шийдвэрлэх арга зам, түншлэл хамтын ажиллагаа, оролцоог хангах талаар НҮБ-ын Ази, номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комисс болон Монголын талаас холбогдох хүмүүс зэрэгцүүлэн илтгэл тавьж хэлэлцүүлэв. Уг хэлэлцүүлгээс УИХ, Засгийн газар, орон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж байгууллага, иргэн өрх гэр бүлд хандсан зөвлөмжийг гаргалаа. НҮБ-ын АНДБЭЗНК-оос Монгол Улсад 4 жилийн хугацаатай 4 орчим сая долларын төсөл хэрэгжүүлэхээр боллоо.

Тэнэмэл амьдралтай хүмүүсийг улсын хэмжээнд судлах, санал боловсруулах ажлын хүрээнд орон нутгаас ирүүлсэн судалгааг нэгтгэж, авах арга хэмжээний талаар санал боловсруулж байна. Мөн энэ ажлын хүрээнд Засгийн газрын 2003 оны 138 дугаар тогтоолоор баталсан “Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх дэд хөтөлбөр”-ийн биелэлтийг гаргаж байна.

Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийн үйл ажиллагааны стратеги, бүтэц, зохион байгуулалтын асуудлыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн хуралдааныг хоёр удаа зохион байгуулав.

Хөдөлмөрийн зах зээлийн бодлого, зохицуулалтын талаар:

“Гадаадаас 2005 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай” Засгийн газрын тогтоол гаргаж, дотоодын ажиллах хүчний мэргэжлийн түвшин чадавхи нь шаардлага хангахгүй байгаагийн зэрэгцээ тухайн үйлдвэрлэл нь манай орны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөх ач холбогдолтой нэхмэл, оёдол, арьс шир боловсруулах болон гол төлөв улирлын чанартай хийгддэг алт болон бусад үнэт металын хайгуул олборлолт, газар тариалан, төмөрлөг болон төмөр эдлэл үйлдвэрлэлийн салбарт гадаадаас авах ажиллах хүчний хувь хэмжээг дунджаар 2-3 пунктээр нэмэгдүүлэхээр тусгав.

Мэргэжлийн сургалтын дэд бүтцэд хамрагдаж буй Өвөрхангай аймгийн бүсийн арга зүйн төв, бизнес инкубаторын төвд Модульд суурилсан ур чадварын сургалт зохион байгуулах сургалтыг дакумын арга зүй дээр тулгуурлан зохион байгуулав.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөдөлмөр эрхлэлтийн газар, Улсын нийгмийн халамжийн газрыг нийлүүлэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болгон өөрчилсөнтэй холбогдуулан “Мэргэжлийн ур чадварын шалгалт зохион байгуулах, мэргэжлийн гэрчилгээ олгох журам”-ыг шинэчлэн батлав.

НХХЯ, Солонгосын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн төв”-ийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэд байгууллаа.

Монгол Улс “Албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн тухай”, Албадан хөдөлмөрийг устгах тухай” ОУХБ-ын конвенциудад нэгдэн орох асуудлыг УИХ-ын нэгдсэн чуулганаар соёрхон батлуулав.

Монгол Улсын Засгийн газар, МАОЭНХ, МҮЭХ-доос ОУХБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Зохистой хөдөлмөрийн үндэсний төлөвлөгөө” сэдэвт гурван талт семинарыг зохион байгуулав. Семинараар зохистой хөдөлмөрийн хомсдолыг арилгах талаар хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөөг эцэслэн хэлэлцэж, хэрэгжилтэнд олон улсын төсөл хөтөлбөрүүд, нийгмийн түншлэгч талуудын үйл ажиллагаа, олон улсын байгууллагуудаас авах техник, арга зүйн дэмжлэгийг нарийвчлан тодорхойлох, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зэрэг амьдралд бодитойгоор хэрэгжихэд чиглэсэн асуудлаар гурван тал харилцан зөвшилцсөнөөрөө семинар ач холбогдолтой боллоо.

“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах Үндэсний хөтөлбөр /2005-2010”-ийг батлав. Хөтөлбөрийн зорилго нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулах, хөдөлмөрлөх үйл ажиллагааны явцад ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, ажилтныг мэргэжлийн эрсдлээс хамгаалах эрх зүйн болон нийгмийн баталгааны түвшинг нэмэгдүүлэх, нийгмийн түншлэлийн механизмыг хөгжүүлэхэд чиглэгдэх юм.

Залуучуудын зохистой, бүтээмжтэй хөдөлмөрийг дэмжих төслийг ОУХБ, Засгийн газар хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь залуучуудын зохистой, бүтээмжтэй хөдөлмөрийг дэмжих талаар мэдлэгийн хүрээг өргөтгөх, мэдлэгийг сонирхогч талууд харилцан солилцох, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр, стратеги боловсруулах, хэрэгжүүлэхийг дэмжихэд чиглэгдэнэ. Төслийн үйл ажиллагааны 2005-2007 оны төлөвлөгөө боловсруулж, ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж ОУХБ-д хүргүүлэв. Төслийн санхүүжилтийн гэрээнд ОУХБ-ын Ази, Номхон далайн бүсийн товчооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд нар гарын үсэг зураад байна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2005-2006 оны улсын хэлэлцээрийг 2 жилийн хугацаатайгаар байгуулав. Улсын хэлэлцээрт татварын багц хуулинд өөрчлөлт оруулах замаар нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээг бууруулж 10 хувьд хүргэх, хүн амын орлогын албан татварын хөнгөлөлтийн доод хэмжээг нэмэгдүүлж, 2005 онд 60.000 төгрөгт хүргэх, “Дөчин мянган орон сууц хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зэрэг хөдөлмөрийн харилцаатай холбоотой эдийн засгийн асуудлууд, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг улсын хэмжээний дундаж цалингийн 50 хувиас

дээш байлгах бодлого баримталж, өмнөх оны инфляцийн түвшинг харгалзан шинэчлэн тогтоох, төрийн албан хаагчид болон төсөвт байгууллагад ажиллагсадын цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг 2005 онд 10-аас доошгүй хувиар, 2006 онд 15-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг хэмжээг бууруулж 1995 оноос өмнө ба хойно тогтоогдсон тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг арилгах арга хэмжээг үе шаттайгаар авах зэрэг хөдөлмөрийн харилцааны болон нийгмийн хамгааллын асуудлууд тусгагдсан болно.

Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай, Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай, Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай УИХ-ын тогтоолын төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлэв.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Аж ахуйн нэгж байгууллагад Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн менежментийн систем нэвтрүүлэх” талаар тусгагдсан зорилтын хүрээнд БНСУ-ын туршлагаас суралцах 10 хоногийн сургалтыг УМХГ-ын 14 эрүүл ахуйн улсын байцаагчдыг оролцуулан зохион байгуулав.

Барилгын засал чимэглэл, барилгын өрөг угсралт-сантехникт 20 багш, Өвөр Монголын ХААИС-д фермерийн сургалтанд 13 багш хамрагдсан сургалтыг зохион байгуулж байна. Төгсөгчид орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй гэрээ байгуулсны үндсэн дээр түр сургалтыг ажилгүй иргэдэд зохион байгуулах юм.

Олон Улсын хөдөлмөрийн Байгууллага /ОУХБ/-ын 105, 29 конвенцийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ОУХБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр олон улсын семинарыг зохион байгуулсан. Уг семинарт Ази номхон далайн бүсийн 10 гаруй орны гурван талт төлөөлөгчид, ОУХБ болон үндэсний холбогдох байгууллагын ажилтнууд зэрэг 60 гаруй хүн оролцов. Семинар нь албадан хөдөлмөрийн асуудлаар олон улсын хэмжээнд нэгдсэн ойлголтод хүрэх энэ чиглэлэр оролцогч орнуудаа ОУХБ-аас авах техник арга зүйн тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой болов.

Гадаад хамтын ажиллагааны талаар:

ОУХБ-ын 93 дугаар чуулган Женев хотноо болов. ОУХБ-ын чуулганд оролцож буй улс орнууд нийгмийн гурван талт болох Засгийн газар, ажил олгогч, ажилчин гэсэн төлөөллөөр оролцох үүрэгтэй байдаг бөгөөд ОУХБ-ын гишүүн 178 орноос 166 орны 2684 төлөөлөгчид гурван талт бүрэлдэхүүнээр оролцлоо. Чуулганы үеэр Конвенц зөвлөмж, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, загасны салбар дахь хөдөлмөр эрхлэлтийн асуудлуудаар тусгай хороодын хуралдаан болсноос манай төлөөлөгчид Конвенц зөвлөмж, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны тусгай хороодын хуралдаанд идэвхитэй оролцож энэ чиглэлээр Монгол Улсын авч хэрэгжүүлж буй бодлого, тохиолдож буй бэрхшээл, Монгол Улс ОУХБ-ын хамтын ажиллагааны талаар цаашид авч хэрэгжүүлэх бодлого зорилтын талаар байр сууриа илэрхийлэв.

Чуулганы үер хоёр талын харилцааны асуудлаар дараах уулзалтуудыг хийж, холбогдох асуудлаар санал солилцов. Үүнд:

- ХБНГУ-ын Эдийн засаг, хөдөлмөрийн яамны Парламентын Төрийн нарийн бичгийн дарга тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж, яам хооронд байгуулах Хамтын ажиллагааны Харилцан Ойлголцлын санамж бичгийн төслийг эцэслэн зөвшилцөж, Ерөнхий сайд Ц.Элбэгдоржийн ХБНГУ-д хийх айлчлалын үеэр энэхүү санамж бичигт гарын үсэг зурав. Уг санамж бичигт гарын үсэг зурснаар хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын цаашдын хамтын ажиллагааны эхлэл тавигдах бөгөөд тухайн салбарын 3-4 боловсон хүчнийг ХБНГУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн агентлагт 3-6 сараар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, Улаанбаатар хотноо Хөдөлмөрийн бирж байгуулах үйл ажиллагаанд техникийн болон мэргэжлийн дэмжлэг тусалцаа үзүүлэх ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлэх боломж нээгдэж байгаа юм.

- ОУХБ-ын Зүүн Азийн бүсийн захирал хатагтай Кристин Еванс Клок, ОУХБ-ын Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Мухамед Муктада, БНСУ-ын Засгийн газрын төлөөлөгч ноён Жи Дун Чой болон албаны бусад ажилтнуудтай уулзав. Уулзалтын үер “Монголын залуучуудыг зохистой, бүтээмжтэй хөдөлмөрөөр дэмжих” төслийн гэрээнд НХХ-ийн сайд Ц.Баярсайхан, ОУХБ-ын Зүүн Азийн бүсийн захирал хатагтай Кристин Еванс Клок нар гарын үсэг зурав.
- Монгол Улсад залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийг БНСУ-ын санхүүжилтээр энэ жилээс эхлэн хэрэгжүүлж, 2006, 2007 онуудад сунгах боломжтой юм. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хөтөлбөрийг боловсруулсан байх, тодорхой бодлого хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байх зэрэг төслийн хүрээнд хийгдэх гол чиглэлүүдийн талаар ярилцан санал бодлоо солилцов.
- ОУХБ-ын Нийгмийн харилцааны секторын эрхлэгч хатагтай Салли Пикистон, ОУХБ-ын Зүүн Азийн бүсийн захирал хатагтай Кристин Еванс Клок, ОУХБ-ын Хятад, Монголыг хариуцсан товчооны дарга хатагтай Констанс Томас болон ОУХБ-ын албаны бусад ажилтнуудтай уулзалт хийж, манай улсын гурван талт, нийгмийн түншлэлийн харилцаа болон түүнийг хэрхэн сайжруулах, энэ чиглэлээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ярилцаж санал бодлоо солилцов.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн талаар:

2005 оны 5 дугаар сард нийгмийн даатгалын тэтгэвэрт 50,4 тэрбум төгрөг олгохоос 50,4 тэрбум төгрөгийн тэтгэвэрийг бүрэн олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод 43,99 тэрбум төгрөг оруулахаас 48,1 тэрбум төгрөг оруулж төлөвлөгөөг 109,4 хувиар биелүүлжээ. Нийгмийн даатгалын тэтгэврийн санхүүжилтэд 48,8 тэрбум, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтэд 8,8 тэрбум, тэтгэмжийн даатгалын санхүүжилтэд 1,9 тэрбум, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санхүүжилтэд 1,6 тэрбум, ажилгүйдлийн даатгалын санхүүжилтэд 526,3 сая төгрөг, нийгмийн даатгалын санхүүжилтэд нийт 61,6 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн авлага 9309,0 сая төгрөг байгаагийн 9991,5 сая төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 682,6 сая төгрөг нь төсөвт байгууллагаас авах авлага байна.

Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн талаар:

2005 оны 5 дугаар сард өссөн дүнгээр нийгмийн халамжийн тэтгэврийг 41838 хүнд олгож 3.0 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 418310 хүнд олгож 9,3 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээнд 15231 хүн хамрагдаж, 139.4 сая төгрөг, тахир дутуу иргэнд үзүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд 8102 хүн хамрагдаж 344.3 сая төгрөг, ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт үйлчилгээнд 38552 хүн хамрагдаж 726.3 сая төгрөг тус тус зарцуулжээ. Нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 524636 хүн хамрагдаж 13.7 тэрбум төгрөг зарцуулсан байна.

БАЙГАЛЬ ОРЧИН

“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Ус рашаан ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлээ.

Мод, модон материал, тарьц суулгацын импортыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барилаа.

Ойн бодлого зохицуулалтын хүрээнд эх орны “Ногоон хэрэм” хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталж, “Ногоон хэрэм” хөтөлбөр хэрэгжүүлэх 2 жилийн төлөвлөгөөний төслийг боловсрууллаа.

Бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, мод, сөөгний тарьц, суулгацын гаалийн импортын болон нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх тухай Монгол Улсын хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийг УИХ-аар батлуулаа.

“Мянган угалзтыг хамгаалах нутгийн ардын холбоо”-ны боловсруулсан цоохор ирвэсний тархац бүхий Ховд аймгийн Цэцэг сумын Хавцгайтын үзэсгэлэнт газрыг хамгаалах, өсвөр насныханд байгаль хамгааллын ач холбогдлыг таниулах зорилгоор 21.8 сая төгрөгийн зардал бүхий “Хавцгайн цоохор ирвэс” төслийг хэрэгжүүлэх зарим эх үүсвэрийг орон нутгийн 2006 оны төсөвт тусгуулж, дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллахаар тохиролцлоо.

Шүлхий гарах магадлалыг бодитой тогтоох зорилгоор судалгаа, шинжилгээний зориулалтаар Дундговь аймгийн Өндөр шил сумын нутгаас 10 толгой цагаан зээр агнах зөвшөөрлийг Улсын мал эмнэлэгийн төв лабораторид хүргүүлэв.

Дэлхийн банкны дэмжлэгээр хэрэгжүүлэх ойн менежментийн төсөл, Богдхан ууланд 1 сая мод тарьж ургуулах тухай үйл ажиллагаануудыг олон нийтэд сурталчлах зорилгоор санал солилцох уулзалтыг зохион явууллаа.

Удаан задардаг органик бохирдуулагчдын нарийвчилсан тооллогын хүрээнд полихлор бифенил агуулсан тосон тоног төхөөрөмжийн тооллогыг эрчим хүчний салбарын цахилгаан түгээх, дамжуулах сүлжээ ба дулааны станцууд зэрэг 40 томоохон үйлдвэр аж ахуйн нэгжүүдийг хамруулан улсын нэгдсэн бүртгэл бий болголоо. Полихлорт диоксон ба фураны эх үүсвэрүүдийг тооллогын хүрээнд НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн газрын олон улсын экспертийн туслалцаатайгаар манай оронд байгаа эх үүсвэрүүдийг тогтоож өөрийн орны нөхцөлд тохирсон тархалтын коэффициентүүдийг сонгосноор цаашид үүсэж байгаа диоксин ба фураны хэмжээг тодорхойлох бололцоотой боллоо.

Улаанбаатар Бээжингийн холбооны телеграфын сувгийг өндөр хурдтай телефон сувагт шилжүүлэх ажлыг БНХАУ-ын Сүлжээний төв, Монголын “Харилцаа холбоо” ХК, УЦУОШГ-тай хамтран туршилтын журмаар ажиллуулж эхэллээ.

“Агаар мандал дахь хүлэмжийн хийн хэмжээг дэлхийн уур амьсгалын системд аюул учруулах түвшинд хүрэхээс өсөж, бууруулах”-д чиглэсэн олон арга хэмжээ авч байгаа бөгөөд энэхүү арга хэмжээг зохицуулагч Киотогийн протокол хүчин төгөлдөр болсныг хүлээж авах ёслолын арга хэмжээг зохион явууллаа.

Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар 20 аймгийн төвийг сансрын хиймэл дагуулын холбооны VSAT системд шилжүүлснээр төв орон нутгийн мэдээллийн сүлжээний хяналтанд гарах мэдээллийн хэмжээ эрс нэмэгдэн 98-100 хувьд хүрлээ.

БОЯ, НҮБХХ хамтран хэрэгжүүлдэг төслийн талаар авч хэлэлцэн, “Дорнод Монголын Биологийн төрөл зүйлийг хамгаалах” төслийн төгсгөлийн үе шат хэрэгжиж буйтай холбогдуулан төслийн санхүүжилтийн үлдсэн хөрөнгийг Байгаль орчны сургалт сурталчилгаа, мэдээллийн төв байгуулахад зарцуулах Засгийн газраас нэмэлт санхүүжилт гаргахаар тохиролцов.

Ус цаг уур, орчны шинжилгээний газарт Монгол, Голландын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд “Гангын гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлчээрийн менежмент” төслийг энэ оноос эхлэн хэрэгжүүлэхээр тохиролцов.

Кени Улсын нийслэл Найроби хотноо болсон Дэлхийн Байгаль орчны сайд нарын дээд хэмжээний 23 дугаар уулзалтад оролцов. Уулзалтад дэлхийн 100 гаруй орны байгаль орчны сайд, дэд сайд, олон улсын болон донор байгууллагын төлөөлөгчид оролцож, тогтвортой хөгжил, байгаль орчны тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн зөвлөмжүүдийг гаргасан.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Аюултай хог хаягдлыг ашиглах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”, “Аюултай хог хаягдлыг паспортжуулах журам”-ын төслийг боловсруулав.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Усны хэрэг эрхлэх газар байгуулан, "Ногоон хэрэм сан"-д хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах журмын төслийг боловсруулав.

"Ойн тухай" хуулийг боловсронгуй болгох, "Иргэдийн оролцоотой ойн нөөцийн менежементийн эрх зүйн асуудлууд", "Ойн нөөцийн хамтын менежементийн гэрээ эрх зүйн асуудлаарх үндэсний семинар болов.

Богдхан уулын дархан цаазат газрын халиун бугыг хамгаалах, өсгөж үржүүлэх менежмент төлөвлөгөөг хэрэгжүүлэх, халиун буга сэргээн нутагшуулах ажлын хүрээнд Хустайн нурууны Байгалийн цогцолборт газраас 10 толгой согооны илий барих, тэжээж арчлах туршилт-судалгааны ажлыг ШУА-ийн Биологийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулахаар шийдвэрлэв. Мөн халиун буга хамгаалах, өсгөн үржүүлэх талаарх Төв аймгийн Мөнгөнморьт сумын "Эрдэнэ-согоо" хоршооны байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрхийг сунгахаар шийдвэрлэв.

Монгол-Америкийн эрдэмтдийн бага хурлыг зохион байгуулсан бөгөөд Эг-Үүрийн сав газрын биологийн төрөл зүйлийн судалгаа, шинжилгээний зориулалтаар Хөвсгөл аймгийн Алаг эрдэнэ, Хатгал, Түнэл, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Эрдэнэбулган, Булган аймгийн Тэшиг, Хутаг-Өндөр сумдын нутгаас тогтоосон хугацаанд загас барьж радио датчик суулгах, тэмдэг тавьж эргүүлж тавих, загас агнах зөвшөөрөл Байгаль хамгаалах "Монголын тул" санд олгов.

2005 онд Арабын орнуудтай гэрээлэх идлэг шонхорын тооны дээд хязгаарыг тогтоолоо.

Монголын оюутны холбоо, Байгаль орчны сургалт судалгааны "Эко Ази" дээд сургуультай хамтран экологийн чиглэлээр суралцдаг оюутнуудын дунд эрдэм шинжилгээний бага хурал зохион явууллаа. Хуралд оролцогчид байгаль орчны хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, түүнд олон нийтийн оролцоог дээшлүүлэх талаар хэлэлцэн, санал бодлоо солилцов.

Байгаль орчны сайд Гандантэгчилэн, Зүүн хүрээ Дэчинчойнхорлин хийд, Бэтүб зэрэг 10 орчим сүм хийдийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзан, Байгаль хамгаалах үйлст хамтран ажиллахаар боллоо.

"Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гадаад орнууд, донор байгууллагуудын тусламж, санхүүгийн дэмжлэг олох зорилгоор Донор байгууллагуудын төлөөллийг Байгаль орчны сайд хүлээн авч "Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийг танилцууллаа. Түүнчлэн НҮБХХ-ийн газартай хамтран Донор байгууллагуудын зөвлөлдөх уулзалтыг Улаанбаатар, Бээжин хотноо тус тус зохион байгууллаа.

ОХУ-ын Якутын Бүгд Найрамдах Улсын Якутск хотноо болсон Дэлхийн цаа буга хамгаалагчдын холбооны III их хуралд оролцож, гэрийн цаа бугын сүргийн цусыг сэлбэх зорилгоор гаднаас цаа буга авчрах хөрөнгө санхүүгийн асуудлыг Норвегийн Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэхээр тохиролцов.

Засгийн газраас баталсан "Ногоон хэрэм" хөтөлбөрийн хүрээнд 13 аймгийн нутагт 315 га ойн зурвас газарт суулгац тарьж, худаг гаргах, хамгаалалтын хашаа барих ажлыг хийгээд байна.

Засгийн газрын 2005 оны 46 дугаар тогтоолын дагуу Усны хэрэг эрхлэх газар байгуулан үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг батлан ажиллаж байна.

"Идлэг шонхор хамгаалах зохистой ашиглах тухай" Засгийн газрын 2002 оны 163 дугаар тогтоолын дагуу Саудын Араб, Кувейт зэрэг орнуудын шейхүүдтэй идлэг шонхор барих гэрээ хийлээ. Уг гэрээний дагуу шонхорын төлбөр болох 360 000 ам.долларыг Сангийн яамны дансанд төвлөрүүллээ.

Хангайн нурууны байгалийн цогцолбор газарт хяналт шалгалт хийж, тус хамгаалалтын захиргааг Хархорин суманд шилжүүлэн байршуулав.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах 4 харуулаас нийт 200 сорьц авч, хүхэрлэг хий болон азотын давхар исэл гэсэн 2 үзүүлэлтийг шинжлэн тодорхойлов. Шинжилгээний дүнгээс харахад хөтөлбөрийн биелэлт УБ-1 харуул дээр 100%, УБ-2 харуул дээр 90.7%, УБ-3 харуул дээр 85.3%, УБ-4 харуулд 100%-тай байлаа. Азотын давхар ислийн дундаж агууламж 0.028 мг/м³, хамгийн их нь 0.072 мг/м³-д хүрч, нийт 100

ажиглалтаас 28 нь агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас тус тус давсан байна.

Үйлдвэрийн хаягдал усны сорьцыг Улаанбаатар хотын дүүрэг дэх таван цэвэрлэх байгууламжийн орох, гарах цэгээс нийт 10 сорьц авч бохирдлын болон химийн задлан шинжилгээ хийв. Шинжилгээний дүнд цэвэрлэх байгууламжуудаас гарч байгаа ус 12-85%-ийн цэвэршилттэй байна.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ

Барилга, хот байгуулалтын салбарын хэтийн хөгжлийн чиглэлээр бодлого

“40 000 орон сууц” хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлж эхэлсэнээр төрийн албан хаагч, бага орлоготой айл өрх, нийгмийн эмзэг бүлэг, нийт ард иргэдийн худалдан авах чадварт нийцсэн хямд өртөгтэй, чанартай орон сууц барьж хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, сайжруулах бодит нөхцөлүүд бүрдэнэ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэх саналын анхны хувилбарийг боловсруулан, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн бариад байна. Төслийг Ерөнхийлөгч зарчмын хувьд дэмжсэн бөгөөд одоогийн байдлаар Ерөнхийлөгчийн өгсөн санал, зөвлөмжийг тусгах, төсөл боловсруулсан мэдээллийн зарим өгөгдлүүдийг шинэчлэх, иргэдэд танилцуулж сурталчлах, ард нийтээр хэлэлцүүлэх ажлуудыг зохион байгуулж байна. Уг төсөл батлагдсанаар эдийн засгийн хувьд орон нутаг бие даан хөгжих чадавхи нь нэмэгдэж, боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг төрийн үйлчилгээг сайжруулах, чанар хүртээмжийг нь дээшлүүлэх бололцоо нөхцөл бүрдэнэ.

Монгол Улсын тулгуур төв 8 хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсрууллаа. Мөн Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Ховд, Улиастай, Зуунмод, Өндөрхаан, Чойбалсан, Эрдэнэт, Дархан хотуудыг жишиг хот болгон хөгжүүлэх төсөл боловсруулах ажлын хэсгийг УИХ-ын даргын захирамжаар аймаг тус бүрээр нь байгуулан ажиллууллаа. Төслийн гол зорилго нь тухайн хотууд хөгжлийнхөө чиг хандлагаар бие биенээ давтахгүйгээр орон нутаг, ард иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлдвэр, үйлчилгээний газруудыг барьж байгуулах, түүнийг нь улсаас хөрөнгө оруулалтын болон гааль, татварын бодлогоор дэмжих хууль эрх, зүйн нөхцөлийг бүрдүүлж улмаар хотуудын хөгжлийн загварыг буй болгох юм.

Хархорин хотыг нийслэлийн чиг баримжаатай, олон улсын жишиг хот болгон хөгжүүлэх төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэв. Төсөл батлагдсан нөхцөлд 2007-2010 онд төлөвлөлт судалгааны ажил дуусаж, дэд бүтцийн сүлжээ буй болж эхлэх бөгөөд 2015 онд барилгажилтын ажлыг эхлүүлэн улмаар 2020 он гэхэд биеэ даасан статустай хот болох юм.

“Дөчин мянга орон сууц” хөтөлбөрийн хүрээнд шинээр газар сонгож дэд бүтэц барих замаар амины 15 мянган орон сууц бүхий шинэ хотхон хороолол барих, хотын доторх газарт дэд бүтцийн нөөцийг ашиглах замаар нийтийн зориулалттай 10 мянган орон сууц барих, гэр хорооллыг цэвэр бохир усны шугам сүлжээнд холбож 15 мянган айлын орон сууцны нөхцөлийг сайжруулах зэрэг төлөвлөлтийн ажлуудын төслийг боловсрууллаа.

“40000 орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Герман улсын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор Баянголын аманд барихаар төлөвлөж байгаа 1000 айлын орон сууц, //Мянганы хотхон/ түүнийг дагалдан барих соёл, үйлчилгээний барилгуудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, энэ оны 7-р сард дуусгахаар ажиллаж байна.

Нийслэлийн хэмжээнд орон сууцанд ашиглагдаж байгаа нийт цахилгаан шатуудын 80 гаруй хувь нь ашиглалтын хугацаа дуусан оршин суугчдын аюулгүй байдалд ноцтой хүндрэл учруулж байгаа тул дээрх байдалд дүгнэлт хийж, эдгээр цахилгаан шатуудын техникийн нөхцөл байдал, аюулгүйн ажиллагааны талаарх

судалгаа, тооллого хийж, дүгнэлт гарган, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Барилгын машин механизмын талаар төрөөс баримтлах бодлого чиглэлийг тодорхойлох, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, тухайлбал машин механизмын бүсчилсэн бааз байгуулах, нэгдсэн мэдээллийн сантай болох зорилгоор Монгол Улсын хэмжээнд барилгын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад ашиглагдаж байгаа машин механизм, тоног төхөөрөмжийн судалгааг аймаг, дүүрэг тус бүрээр нь гаргуулан нэгтгээд байна.

Хот, суурин газруудын ундны усны чанарыг сайжруулах хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Бага орлоготой иргэдийг орон сууцаар хангах бодлого боловсруулах ажлын хүрээнд “Хотжилт ба бага орлоготой иргэдийн орон сууцны хэрэгцээ” Үндэсний хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулав. Үндэсний хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Уг хэлэлцүүлгийн үр дүнд гадаад улс орны орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, сайжруулах талаар хийгдэж буй ажлын талаар мэдээлэл авсан. Мөн гадаад орнуудын орон сууцны хангамжийн талаарх туршлагыг судлах, тэдний дэмжлэг авах, цаашид 4 жилийн хугацаанд бага орлоготой иргэдийг орон сууцтай болгох зорилгоор 4.0 сая ам долларын төсөл хэрэгжүүлэхээр болоод байна.

Газар өмчлөлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг төслийг батлууллаа. Хуулийг дагаж мөрдөх журманд өөрчлөлт орсноор газар өмчлөх ажил ард түмэнд илүү хүртээмжтэй, Дархан, Эрдэнэт хотод газар өмчилж авах боломж бүрдсэн. Монгол Улсын Иргэнд эрхийн бичгээр газар өмчлүүлэх хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулаад байна.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, газрын тухай багц хууль болон тэдгээрийн өөрчлөлттэй болон бусад хууль эрхийн баримт бичгүүдтэй уялдуулж Хот байгуулалтын тухай хуулийг шинэчлэн найруулж дуусган мэргэжлийн байгууллагуудаар хэлэлцүүлж байна. Энэхүү хууль батлагдан гарснаар манай улсын хот төлөвлөлт, байгуулалтын ажил олон улсын жишигт ойртох боломж бүрдэн газар өмчлөх, ашиглах, эзэмших, түрээслэх, болон газрыг эргэлтэнд оруулахтай холбоотой олон асуудлууд шийдвэрлэгдэх хууль эрх, зүйн орчин буй болно.

Ипотекаар баталгаажсан үнэт цаасны санхүүгийн бүтэц, тогтолцоо, хууль, тогтоомжийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ипотекаар баталгаажсан хэд хэдэн орны загвараас Монгол Улсын макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд тохирох холимог загварын төсөл боловсруулсан бөгөөд энэхүү загвартай уялдсан “Ипотекээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн төслийг боловсруулаад байна.

Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил, нийтийн аж ахуйн үйлчилгээ, цахилгаан шат, өргөх краны угсралт, засвар үйлчилгээ, зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох журмыг батлан, мөрдүүлж байна.

Барилгын төсөв зохиоход хэрэглэдэг зам, барилгын ажилчдын цагийн тарифт цалингийн жишгийг шинэчлэн батлуулж, 2005 оны 7-р сарын 01-ээс эхлэн мөрдүүлэв.

Улаанбаатар хотод баригдаж буй орон сууцны барилгын тооллогыг хийгээд байна. Эхний хагас жилийн байдлаар 1579 орон сууц ашиглалтад оруулж, орон сууцны барилга угсралтын ажил эхлэх 1000 гаруй зөвшөөрөл олгоод байна.

Сүхбаатар дүүргийн 15-р хороонд “Гэрэлт хотхон” гэр хорооллын төслийг АХБ-ны тусламжтайгаар хийхээр тохиролцож, мөн “Олон нийтийн оролцоотой гэр хорооллыг хөгжүүлэх загвар төсөл”-ийг Дамбадаржаагийн гэр хороололд хэрэгжүүлэх юм.

“Дөчин мянган орон сууц” хөтөлбөрт газрын чиглэлээр дэвшүүлсэн зорилтын хүрээнд 5 төрлийн үйл ажиллагааг төлөвлөөд байна. Аймгийн төв хотуудын “Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд тусгагдсан орон сууцны төлөвлөлт, байршил, газар ашиглалтын талаар судалгааны мэдээллийг авч дүгнэлт хийв. Мөн нийслэлийн 2005 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 131.54 га газрыг орон сууцны зориулалтаар олгохоор тусгагдсны гадна хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний

дагуу орон сууцны зориулалтаар олгогдсон газрын судалгааг гаргав. Гэр хорооллын төлөвлөлт шинээр хийгдэх газрын байршлыг сонгож кадастрын зурагт баталгаажуулав.

ЗАМ ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЧЛАЛ

Төрийн өмчит “МИАТ” хувьцаат компанийн өмчийн дийлэнх хувийг буюу 51.0 хувийг Зам тээвэр, аялал жуулчлалын яаманд шилжүүлэх асуудлыг Засгийн газрын хэлэлцүүлэн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд чиглэлийн яам, мэргэжлийн байгууллагын төлөөллийг түлхүү оролцуулах замаар удирдлагаар ханган ажиллахаар шийдвэрлэв.

“Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн ерөнхий төлөвлөгөө гаргаж батлуулав.

Авто зам, замын байгууламжийг барих тусгай зөвшөөрөл олгох шинэчилсэн журам, мөн гүүрийн арчлан хамгаалагч, засварчны ажиллах нэг жилийн жишиг зардал, арчлан хамгаалагчтай байх гүүрүүдийн жагсаалт, зам тээврийн хяналт зохицуулалтын албадан ажиллах журам, төлбөртэй цэгийн байршил, төлбөр авах чиглэл, замын уртын хэмжээ зэргийг боловсруулж батлуулаад байна.

“Улаанбаатар хотын хөдөлгөөний менежментийг сайжруулах” төслийн хүрээнд тооллого судалгааны ажил явуулж, урьдчилсан үр дүнгээр уулзалт зохион байгуулав.

АХБ-ны техникийн тусламжийн хүрээнд Монгол Улсын Тээврийн стратегийг боловсруулах төслийн зөвлөх байгууллагаар Канадын CPCS компани шалгаран үйл ажиллагаагаа эхлээд байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгслээр улс хоорондын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад тавих техник-ашиглалтын шаардлагыг өндөржүүлэх, уг тээвэрлэлтийг хяналт, зохицуулалтад оруулах зорилгоор “Улс хоорондын ачаа, тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ыг батлан мөрдүүлэв.

Хархорин-Цэцэрлэгийн 46.0 км замыг ашиглалтад хүлээн авлаа.

Япон Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжих “Зүүн чиглэлийн гол авто зам барих” төслийн Хэлэлцээрт талууд гарын зурсан.

Тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд учруулж буй сөрөг үр дагаврыг багасгах зорилгоор Дэлхийн банк болон Нордикийн хөгжлийн сангийн урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг, оношлогоо хийх төвүүд байгуулах, бүртгэлийн нэгдсэн сүлжээ бий болгох” дэд төслийн хүрээнд Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогооны 3 төв баригдахаас эхний ээлжинд Сонгино-Хайрхан дүүрэгт баригдсан төвийг байнгын ашиглалтад хүлээн авав.

Монгол Улсын Засгийн газар болон БНАСАУ-ын Засгийн газар хооронд байгуулах “Далайн худалдааны тээврийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-т Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд гарын үсэг зурахаар болов.

Монголын Хөлөг онгоцны бүртгэлийн Хамтарсан компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд шинээр 23 хөлөг бүртгэгдэж нийт хөлөг онгоцны тоо 753 болоод байна.

“Далайн навигацийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” конвенц, түүний нэмэлт, өөрчлөлт болох “Эх газрын хормойд байрлуулсан суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” протоколыг УИХ-ын холбогдох байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр өргөн бариад байна.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн компанийн Удирдах зөвлөлийн хурлыг Сингапурт зохион байгуулж дараах асуудлыг шийдвэрлэв. Үүнд:

- Хамтарсан компанийн хэлэлцээрийн дагуу энэ санхүүгийн жилээс эхлэн Монголын талын хувьцааг дахин 10.0 мянган хувьцаагаар нэмэгдүүлснээр нийт хөрөнгийн 50.0 хувьтай тэнцэх хувьцааг Монгол Улсын Засгийн газар эзэмших болов.

- Удирдах зөвлөлийн гишүүдийг энэ санхүүгийн жилээс эхлэн тэнцүү тоотой буюу 3х3 байхаар тогтож протоколд тусгуулав.

Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны ашгаас манай Засгийн газарт хуваарилагдах улирлын төлбөр болох 88.300 ам. долларыг улсын төсөвт шилжүүлэв.

“Азийн замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг УИХ-аар соёрхон батлуулав. Германы “Сэргээн босголт” банкны зээл тусламжаар хэрэгжих “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-аар соёрхон батлуулахаар өргөн мэдүүлэв.

Дэлхийн банк болон АХБ-ны зээлийн гэрээг шинэчлэх, машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын үр бүтээлийг нэмэгдүүлэх үүднээс “Машин механизм, тоног төхөөрөмжийн урт хугацаат зээлийн гэрээг шинэчлэн байгуулах, зарим хөрөнгийг шилжүүлэн хуваарилах тухай” ЗТАЖ-ийн сайдын тушаал гарган, хэрэгжүүлж байна.

Олон улсын болон улсын чанартай авто замаар зорчих авто тээврийн хэрэгслээс төлбөр авах цэгийн үйл ажиллагааг тогтмолжуулах, төвлөрсөн төлбөрийг захиран зарцуулах ажлыг журамлах зорилгоор авто замын төлбөр хураах цэгүүдийн 2005 оны орлогын төлөвлөгөө, үйл ажиллагааны зардлын хэмжээг батлан мөрдүүлэв.

ОХУ-ын Улаан-Үүд хотноо Монгол, Оросын ЗГХК-ын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын ээлжит V хуралдаанд Алтанбулаг-Хиагтын хилийн боомт дээр хоёр тал тээврийн хяналт шалгалтыг байнга явуулж бүрэн бус тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэх явдлыг таслан зогсоох арга хэмжээг авахын зэрэгцээ суудлын автомашинаар зорчигч тээвэрлэхтэй холбогдсон зохицуулалтын механизмыг “Олон улсын авто тээврийн харилцааны тухай” хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмэлт оруулах замаар тусган хэрэгжүүлэх асуудлыг ОХУ-ын талд тавьж, протоколд тусгалаа.

“Зүүн хойд Азийн олон улсын нэгдсэн тээвэр ба тээвэрлэлтийн оновчтой систем” сэдэвт үндэсний семинар зохион байгуулж, манай улсын тээврийн салбарын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн асуудал, ялангуяа олон улсын тээврийн асуудлыг голчлон ярилцсан бөгөөд үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргалаа.

“Аялал жуулчлалын чуулган”-ыг зохион байгууллаа. Чуулган нь аялал жуулчлалын үйлчилгээ, хөдөөгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь сэдэв 2 салбар хуралдаанаар хуралдаж, нийт 690 орчим төлөөлөгчид оролцсон чуулганаас аялал жуулчлалын салбарынханд уриалга гаргасан.

“Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн-2005”-ыг 6 дахь жилдээ зохион байгуулав.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Шинэ оны анхны нар мандахыг харах тусгай галт тэрэгний аялал”-ыг 3 дахь жилдээ зохион байгуулсан.

Аялал жуулчлалын гол бүс нутгуудад гадаад дотоодын жуулчдыг цаг агаарын ямар ч нөхцөлд, өдөр болон шөнийн цагаас үл хамааран төлөвлөсөн маршрутын дагуу, төөрөхгүй саадгүй аялах бололцоог олгох зорилгоор Монголын аялал жуулчлалын салбарт сансрын хиймэл дагуулын мэдээллийг ашиглан Car navigation буюу байршил тогтоох системийг нэвтрүүлж, эхний ээлжинд Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Сүхбаатар, Хэнтий гэсэн жуулчдын гол маршрутыг хамруулав.

Монгол Улсад өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох зорилгоор Монголын нохойн чарганы холбоотой хамтран Тэрэлж-Горхийн байгалийн цогцолбор газарт нохойн чарганы танилцуулах арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

Монгол орны гадаад сурталчилгааг өргөжүүлэх зорилгоор манай улсын аялал жуулчлалын гол чиглэлийн маршрут, 2005 онд зохиогдох арга хэмжээнүүдийн талаарх мэдээлэл, томоохон тур-оператор, зочид буудал, рестораны хаяг зэргийг багтаасан танилцуулга, лого, CD, зурагт хуудас зэрэг сурталчилгааны материалуудыг хэвлэн гаргаж, гадаад дотоодын сурталчилгаанд ашиглан, шинэ вэб хуудас ажиллуулж байна.

“ЭКСПО-2005” олон улсын үзэсгэлэн яармагийн үеэр Монгол Улсыг сурталчлах зорилгоор “Монголын аялал жуулчлалын өдөр” арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд

Монгол Улсын павильоныг 30000 гаруй хүн сонирхсон болно. Арга хэмжээг NHK, Fuji телевиз, өдөр тутмын Майничи, Чюничи, спортын өдөр тутмын хэвлэл болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан болно.

Монгол Улс ТИР Карнейн хүрээнд барааг Олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенцид нэгдэн орж, авто тээврийн хэрэгслээр гаалийн хөнгөвчилсөн горим бүхий олон улсын тээвэрлэлтийг гүйцэтгэх болж байгаатай холбогдуулан ТИР горимоор гүйцэтгэх тээвэрлэлтийн найдвартай ажиллагааг хангах “Аюулгүйн хуримтлал”-д зориулан хөрөнгө гаргах тухай Засгийн газрын тогтоол гарган шийдвэрлэв.

Тулгар төр байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд Японы хувийн хэвшлийн байгууллагуудын санхүүжилтээр зохион байгуулах “Мянган морьтон” ёслолын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-т гарын үсэг зурлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНУУ-д хийсэн айлчлалын үеэр ЗТАЖЯ болон БНУУ-ын Бүс нутгийн хөгжил, төвлөрлийн асуудал эрхэлсэн яамд “Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-т гарын үсэг зурав.

Жуулчдад үнэн зөв мэдээлэл өгөх зорилгоор жуулчны мэдээллийн төвийн салбарыг “Буянт-Ухаа” олон улсын нисэх онгоцны буудал, төмөр замын “Улаанбаатар” өртөөнд нээлээ.

“Хятад жуулчдыг Монгол Улсад бүлгээр аялахыг хөнгөвчлөн дэмжих тухай Монгол Улсын ЗТАЖЯ, БНХАУ-ын Үндэсний Аялал жуулчлалын газар хоорондын Харилцан ойлголцох санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хятадын жуулчдыг Монгол Улсад бүлгээр аялахыг зохион байгуулах аялал жуулчлалын байгууллагуудыг сонгох түр журам”-ыг батлав.

Бонн хотноо “Чингис хаан ба түүний өв” сэдэвт Монгол Улсын түүх соёлын тухай үзэсгэлэнгийн нээлтийн хэсэгчилсэн зохион байгуулалтыг хийлээ. Үзэсгэлэнд Монгол Улсын бүх томоохон музейнүүдийн сан хөмрөгөөс нийтдээ 450 гаруй үзмэрүүдийг оролцуулснаас гадна Герман, Франц, ОХУ, БНХАУ, Япон, Итали, Ватикан, Швед, АНУ, Иран, Унгар, Тайван зэрэг орнуудын музейнүүдээс Монголын түүх соёлтой холбоотой 230 орчим үзмэр үзэсгэлэнд тавигдсан юм. Үзэсгэлэн яармагийн хажууд 8 ханатай гэрээс гадна нийт 5 гэр барьж, “Монгол хотхон” нэртэйгээр Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах ажлыг зохион байгууллаа.

“Шуудангийн үйлчилгээний дүрэм”, “Хаяг тодорхойгүй болон шуудангаар илгээхийг хориглосон зүйл агуулсан илгээмжийг задлах, устгах журам”-ыг батлав.

“Шуудан, цахилгаан холбоо, мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНБУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамж гаргахаар болов.

ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧ

“Түлш, эрчим хүчний салбарын удирдах ажилтны зөвлөгөөн”, “Удирдлага, менежмент, үр ашиг” сэдэвт онол практикийн бага хурлыг зохион байгуулж, хурлаас цаашид авах арга хэмжээний тухай шийдвэр гарган түүний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж, биелэлтийг хангах талаар хяналт тавин ажиллаж байна.

“Эрчим хүчний салбарын нормативын баримт бичгийг боловсронгуй болгох, шинэчлэх шаардлага” сэдэвт ажлын уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, түүний хүрээнд барилгын салбарын нормативын баримт бичгийг боловсронгуй болгох сангийн дэргэд эрчим хүчний салбар сан байгуулах талаар Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төвийн холбогдох хүмүүстэй уулзаж, зарчмын хувьд тохиролцсоны дагуу “Нормчлолын сан” байгуулах, зарцуулах, хянах журам, “Эрчим хүчний салбарын нормативын баримт бичиг”, “Засварын төсөв зохиох аргачлал” журмуудыг боловсруулж батлуулахаар бэлтгэж байгаа ба Эрчим хүчний үйлдвэр, компаниудын засварын ажлын төсөв зохиох аргачлал боловсруулаад байна.

“Дулаацуулгын зуухны техник ашиглалтын дүрэм”, “0.07 МПа /0.7 кгх/см²/-аас бага даралттай уурын зуух ба 388К /115°C/-ээс доош температуртай ус халаах зуухыг /ус халаагуурыг/ төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм” зэргийг батлан мөрдөж байна.

Оюутолгойн “Тогтвортой байдлын гэрээ”-нд эрчим хүчний талаар өгөх саналтай уялдуулан Ivenhoe mines компанийн болон техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах Японы компанийн хүмүүстэй уулзаж урьдчилсан байдлаар говийн бүсийн цахилгаан хангамжийн судалгаа хийх ажлын хүрээг тохиролцоод байна.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр”-ийн төслийг УИХ-ын тогтоолоор батлуулсан.

Орхоны усан цахилгаан станцыг барьж байгуулах хөрөнгийн эх үүсвэрийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад тавих асуудлаар арга хэмжээ авах, “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв”-ийг байгуулах талаар тодорхой шийдвэр гарган ажиллаж байна.

Сэргээгдэх эрчим хүч-II төслийн хүрээнд ХБНГУ-ын Сэргээн босголтын банкнаас мэргэжилтэн ирж Улаанбаатар хотын ойролцоо орших Хүйтний онгорхойд салхины эрчим хүчний хэмжилт, судалгааны ажил хийхээр тохиролцсон бөгөөд энэ ажилд Сэргээгдэх эрчим хүчний шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн нэгдэл, Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төвийн мэргэжилтнүүд оролцлоо.

Автомашиньг хийн түлшээр цэнэглэх станцын аюулгүй ажиллагааны дүрмийг боловсруулж, “Авто тээврийн хэрэгслийг шингэрүүлсэн шатдаг хийн түлшний нэмэлт төхөөрөмжөөр тоноглох үйлчилгээ, ангилал, ерөнхий шаардлага” гэсэн улсын стандартыг шинээр боловсруулаад байна.

“Дамжуулах сүлжээг шинэчлэх” төслийн санхүүжилтэд Шведийн Засгийн газрын зээлийн гэрээнд гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохоор болов.

“Дулааны үр ашгийн төсөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор төслийн II багцаар гурван талын уулзалтыг зохион байгуулж гүйцэтгэлд гарсан зарим дутагдлыг арилгуулах асуудлыг шийдвэрлэж байна. Мөн уг төслийг эрчимжүүлэх зорилгоор төслийн I багцаар гурван талын уулзалтыг зохион байгуулж, БНХАУ-ын “БЕРИС” компанитай зөвшилцөж чадаагүй тул Төслийн удирдах хороог хуралдуулж “БЕРИС” компанийн ажил хэт удаашралтай байгаа, дэнчингийн хугацаагаа сунгахгүй, ажлын чанарын доголдол гарсан зэргийг үндэслэн гэрээг цуцлахаар шийдвэрлээд байна.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Түгээх сүлжээний алдагдал бууруулах” төслийн зээлийн хөрөнгөөс хэмнэгдэж байгаа хөрөнгийг цаашид ашиглах талаар санал /Баруун бүсийн 3 түгээх сүлжээг шинэчлэх, “УБЦТС” ХК-ийн түгээх 6, 10 кВ-ийн сүлжээнд зарим техникийн шинэчлэлтийг хийх, “ДҮТ” ХХК-д симулятор авах, программ, техник хангамж, хүмүүсийн сургалт г.м/ боловсруулж Дэлхийн банкинд хүргүүллээ.

Богдын голын УЦС-ын сувгийн шинэчлэлийн гүйцэтгэгчтэй гэрээнд гарын үсэг зурж, Тайширын УЦС-ыг барих төслийн хүрээнд шаардагдах шатахууныг гааль, НӨАТ-аас чөлөөлөх шийдвэр гаргуулав.

Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ХК-ний ОХУ-аас импортолж байгаа цахилгаан эрчим хүчийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийг УИХ-аар батлуулан мөрдөж байна.

Увс аймгийн Улаангом хотын дулаан хангамжийн системд улсын төсөв хөрөнгөөр хэрэгжүүлж буй гадна дулааны шугамын өргөтгөл шинэчлэлийн ажлыг улсын комиссоор хүлээж авлаа.

Арвайхээр-Баянтээг-Баянхонгорын 110 кВ, Сүхбаатарын Уулбаян-Мөнххааны 15 кВ, Улиастай-Алдархааны 35 кВ, Дундговь аймгийн Адаацаг сумыг 15 кВ, Сүхбаатарын Уулбаян-Түвшинширээгийн 10 кВ, Өвөрхангайн Төгрөг-Гучин-Ус, Хөвсгөлийн Жаргалант-Завханы Их-Уулын 10 кВ-ийн цахилгаан дамжуулах шугам, дэд станцын барилгын ажлыг дуусган, ашиглалтад хүлээлгэн өглөө.

Завхан аймгийн Богдын голын УЦС-ын төслийг эхлүүлэх гэрээнд гүйцэтгэгч байгууллага БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шар мөрөн, Хөх мөрөн барилга угсралтын компанитай гарын үсэг зурлаа. Мөн төслийн зөвлөх, захиалагч, гүйцэтгэгч

байгууллагын гурван талын уулзалт хийж барилгын ажлыг яаралтай эхлүүлэх талаар тодорхой шийдвэр гаргаж протокол үйлдэв.

Засгийн газрын “Нүүрс” хөтөлбөрийг боловсруулах хүрээнд:

- Нүүрсний хийгээр ажиллах 60-100 кВт чадалтай бичил станцын төслийг Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төвтэй хамтран хэрэгжүүлэхээр тодорхой ажил зохион байгуулж байна. Нүүрсний хийн цахилгаан станц барих техник, эдийн засгийн үндэслэл боловсруулан салбарын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэн туршилтад оруулах шийдвэр гарсан. Нүүрсний хийгээр ажиллах станцыг 2005 оны 7-9 сард Улаанбаатар хотод туршилт явуулсны дараа Говь-Алтай аймгийн Төгрөг суманд суурилуулах төлөвлөгөөтэйгээр ажиллаж тоног төхөөрөмжүүдийг ОХУ, БНХАУ-аас авахаар захиалга өгөөд байна.

- Нүүрснээс утаагүй хатуу түлш үйлдвэрлэх, нүүрсний хийжүүлэлтэд түшиглэсэн эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг хэлэлцэж, бодлогын чиглэлийг тодорхойллоо. “Нүүрсийг шингэрүүлэх буюу нүүрснээс синтетик шингэн түлш гарган авах үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын чиглэл”-ийн төслийг боловсруулаад байна.

- Орон нутгийн засаг захиргааны нэгжийн өөрчлөлт, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн улс орны түлшний хангамжийг сайжруулах хүрээнд авах арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцэн, Монгол Улсын түлшний салбарыг 2005-2010, 2010-2015 онуудад хөгжүүлэх чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж ажиллаж байна. Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд 2005-2006 оны өвөлжилтийн бэлтгэл ажилд одоогоор бэлэн нүүрсний нөөц 80.0 мян.тн, нээж бэлдэх нүүрсний нөөц 2005 оны 6-р сарын 15-ны байдлаар 250.0 мян.тн нүүрсний нөөцтэй байна. Тавантолгойн техникийн бэлэн байдал 100%, Хартарвагатайн нүүрсний уурхай авахад бэлэн нүүрсний нөөц 20.0 мян.тн, техникийн засвар үйлчилгээ 65-70%, Могойн голын нүүрсний уурхай авахад бэлэн нүүрс 12.0 мян.тн, техникийн засвар үйлчилгээ 70%, Багануурын нүүрсний уурхай авахад бэлэн нүүрсний нөөц 250.0 мян.тн, техникийн засвар, үйлчилгээ цаг тухайдаа тогтмол явагдаж байна. Шарын голын нүүрсний уурхай авахад бэлэн нүүрс 30.0 мян.тн нүүрсний нөөцтэй, техник ашиглалтын засвар, үйлчилгээ графикийн дагуу тус тус явагдаж байна.

Нийслэлийн захирагчийн ажлын албатай хамтран Улаанбаатар хотын агаарын бохирдлыг багасгах ажлын хүрээнд шахмал түлшийг хэрэглэж байгаа Бээжин хотын туршлагаас судлах, Багануур уурхайн нүүрсийг Бээжин хотод аваачиж туршилтад оруулах, БНХАУ-ын хөрөнгө оруулалттай шахмал түлшний үйлдвэр барих, хөнгөн хийг халаалтын зууханд хэрэглэх боломжийг судлах ажлын хэсэгт өөрийн яамнаас мэргэжилтэн оролцуулж, БНХАУ-ын талтай дээрх асуудлаар хамтран ажиллах санамж бичиг үйлдэв.

“Юнигаз” компанитай хамтран 500 м³ багтаамжтай хийн агуулахыг олон улсын JLP-1 стандартын дагуу барьж дуусган ашиглалтад өгөхөд бэлэн болгоод байна. Мөн Улаанбаатар хотод 3 ширхэг автомашин цэнэглэх станц барих ажил дуусах шатандаа явж байна. Улаанбаатар хотын такси компанийн таксинуудад хийн баллоны нэмэлт төхөөрөмжүүдийг үе шаттайгаар суурилуулах ажлыг эхэлж одоогийн байдлаар 250 гаруй таксинд үнэ төлбөргүй суулгаж нийтдээ 400 гаруй такси хийн түлшээр ажиллахад бэлэн болоод байна.

Түлш, эрчим хүчний салбарт 2005 оныг “Үр ашгийн жил” болгохоор шийдвэрлэсэнтэй холбогдуулан “Түлш, эрчим хүчний салбарын үр ашгийг дээшлүүлэх хөтөлбөр” баталж, хэрэгжүүлэх арга хэмжээг авч байна. Салбарын үйлдвэр, компаниудын хүрэх зорилтот түвшин тодорхой болсоны зэрэгцээ тэдгээрийн ажлыг

дүгнэхэд нэгдсэн үзүүлэлт, аргачлал ашиглах эхлэл болж өгснөөрөө энэ ажил ач холбогдолтой боллоо.

Дизель станц бүхий Завхан, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын эрчим хүчний үйлдвэрт худалдан авах дизелийн түлшний нийлүүлэгчийг сонгох тендерийг нийт 9 багцаар зарлах, дүгнэх ажлыг зохион байгууллаа. Дээрх 9 багцаас 6 багцад нь нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан. Энэ арга хэмжээний үр дүнд 4 үйлдвэрт одоогийн үнэтэй зэрэгцүүлэхэд 980,0 сая гаруй төгрөгийн хэмнэлт гарахаар байна.

Алдагдалтай ажиллаж, улсын төсвөөс алдагдлын санхүүжилт авдаг эрчим хүчний үйлдвэрүүдийн 2005 оны эхний саруудын санхүүжилтыг тухай бүрд нь олгуулах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Өнгөрсөн 6 сард эрчим хүчний үйлдвэрүүдэд дараах санхүүжилт олгогдлоо. Үүнд:

Баянхонгорын ЭХҮ	960.0 сая төг
Говь - Алтайн ЭХҮ	650.0 сая төг
Завханы ЭХҮ/ Тосонцэнгэлтэй хамт /	1204.0 сая төгрөг / 650.0 саяыг нь
	Засгийн газрын нөөц сангаас/
Даланзадгадын ДЦС	180.0 сая төг
Баруун бүсийн ЦДС	275.0 сая төг
Бүгд	3269.0 сая төг.

“100000 нарны гэр” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Япон Улсын төслийн бус буцалтгүй тусламж, БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр бэлтгэгдсэн нарны цахилгаан үүсгүүрүүдийн үнийн төвлөрүүлэлтийн мэдээг ХААН банк, Төрийн сангаас авч нэгтгэн дүгнэж аймаг тус бүрээр тооцоо гарган төлбөрийн төвлөрүүлэлтийн асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авч байна.

Зүүн хойт Азийн “Түмэн бүс” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад оролцож, “Эрчим хүчний суурь судалгаа, салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх төсөл”-ийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, БНСУ-ын Итгэлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх асуудал шийдэгдлээ.

Салбарын уурхайнуудын хөрс хуулалт, нүүрс олборлолтын төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны сар бүрийн мэдээллээр хангаж ирлээ. Оны эхнээс төвийн бүсийн уурхайнуудын хөрс 7821.1 мян.м³ буюу 92,7%, нүүрс 2290.6 мян.тн буюу 103,0% тус тус байна.

ТЭХ-ний сайд Т.Очирхүү тэргүүтэй төлөөлөгчид ХБНГУ-ын Лейпциг хотод болсон “Шилжилтийн орнуудын Эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлт” сэдэвт хурал, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын хамтарсан комиссын /ЗГХК/-ын 2 дугаар хуралдаанаас гарсан протоколын дагуу Австри Улсын сэргээгдэх эрчим хүчний ашиглалт, хөгжилтэй танилцах сургалт семинар, Эрчим хүчний салбарын сайд нарын уулзалтад оролцож санал солилцлоо. Мөн Монгол, Австрийн Засгийн газар хоорондын хамтарсан комиссын хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэхээр шийдвэрлэснийг үндэслэн Монгол Улсын Түлш, эрчим хүчний яам болон Австри улсын Эдийн засаг, хөдөлмөрийн яамны хооронд сэргээгдэх эрчим хүчийг ашиглах чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичгийг байгууллаа.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч”-ийг шалгаруулсан

Францын тусламжийн улаан буудай хүлээн авахтай холбогдсон гааль, худалдааны татвараас чөлөөлөх, чанарын баталгаажуулалт хийлгэх, хөндлөнгийн болон гааль, хорио цээрийн хяналт хийлгэх арга хэмжээг зохицуулж, эхний ээлжийн 10 вагон улаан буудайг “Алтан тариа” ХК-д хүлээлгэн өгөв. Мөн Япон Улсын тусламжийн улаанбуудайн үнэ тогтоох, хөрөнгө төвлөрүүлэх тухай төсөл боловсруулж, БНХАУ-ын тусламжийн улаанбуудай хүлээн авахтай холбоотой бэлтгэл ажлыг зохион байгуулав.

“Малын индексжүүлсэн даатгал төсөл”-ийн хөгжлийн зээлийн гэрээний тухай УИХ-ын холбогдох байнгын хороодын хуралдаанаар хэлэлцэж дэмжсэний дагуу “Малын индексжүүлсэн даатгал төсөл”-ийн хөгжлийн зээлийн гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулав. Монгол Улсад малын даатгалын үр ашиг багатай уламжлалт хэлбэрийг өөрчлөх, малын хорогдлын улмаас эдийн засагт учрах хохирлыг багасгах оновчтой хувилбарыг нэвтрүүлэх чиглэлээр судалгаа явуулсны үндсэн дээр энэхүү төслийн хөгжлийн зээлийн гэрээг боловсруулсан байна.

“Стандартчилал, хэмжилзүйн Үндэсний зөвлөл”-ийн хуралдаанаас дэмжсэн ХАА-н стандартчилалын техникийн хорооны 2005-2006 оны хөтөлбөрт мал эмнэлгийн салбарт мөрдөх стандартын нэр төрөл, хэрэгжүүлэх хугацааг тохиролцож шийдвэрлэв.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд 2005, 2006 онд хамтран ажиллах “Санамж бичиг”-т Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нар гарын үсэг зурж, нийслэлийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх хотын онцлогт тохирсон эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх асуудлаар ярилцаж санал солилцов.

Японы тусламжийн “КР-1”, “КР-2” төслийн хэрэгжилт, хөрөнгө төвлөрөлтийн талаар мэдээлэл бэлтгэн Японы ЭСЯ-тай ярилцлага зохион байгуулж, “КР-2” төслийг үргэлжлүүлэх, хөрөнгийн бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэв.

“Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2004 онд нийлүүлэгдсэн техникийг борлуулах ажлыг зохион байгуулав. Энэ арга хэмжээний хүрээнд аж ахуйн нэгж, иргэдэд иж бүрдэл трактор, анжис, сүү боловсруулах, савлах төхөөрөмжүүдийг олгож, “Мал хамгаалах сан”-д хөрөнгийг хуримтлуулав.

Хаваржилт хүндэрсэн аймгуудын малчдад хүргэх өвс, тэжээлийн тээврийн зардлыг аймгуудад олгох арга хэмжээ авлаа. Мөн ХААОУС-ийн “Аюулгүй сан”-гаас хөрөнгө зарцуулах тухай хүсэлтийг хэрэгжүүлэхээр “Хөдөөгийн ядуурлыг бууруулах” хөтөлбөртэй хамтран ажиллаж байна. Цагийн байдалтай холбогдуулж ХХХААЯ-н дээр хариуцлагатай жижүүрийг уртасгасан цагаар ажиллуулж, аймаг, орон нутагтай мэдээлэл солилцож, шаардлагатай асуудлыг шуурхай шийдвэрлүүлж ажилласан

“Монголын мал аж ахуйн хөгжил” төслийн хүрээнд Франц Улсаас нийлүүлэгдэж байгаа малын үр, зохиомол хээлтүүлгийн багаж хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлүүлэх асуудлыг шийдвэрлэв.

Малын гоц халдварт шүлхий өвчний вакциныг хүлээн авч, аймгуудад хуваарийн дагуу хүргүүлэв.

Монгол Улсыг үхрийн мялзан өвчний халдваргүй орны жагсаалтад оруулах бэлтгэл ажлын хүрээнд Олон улсын цөмийн атомын энергийн агентлагтай хамтарч 22 аймгийн нийт 17.3 мянган малын ийлдсэд шинжилгээ хийж, дүнг нэгтгэн ДМАЭМБ-ын Шинжлэх ухаан, техникийн зөвлөлд хүргүүлэв.

Эрчимжсэн сүүний аж ахуй эрхлэх иргэн, аж ахуйн нэгжид сүү боловсруулах, савлах тоног төхөөрөмжийг олгох ажлыг зохион байгуулав.

Энэ оны эхний хагас жилд Дундговь, Говьсүмбэр, Төв, Сэлэнгэ аймгийн сумдад үлийн цагаан оготны хаврын тодотгох судалгааны дүнг үндэслэн 100.0 мянган га талбайд энгийн аргаар оготной тэмцэхээр шийдвэрлэв. Мөн энгийн механик аргаар нийт 220.0 мянга га талбайд оготной тэмцэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх ажлын гэрээг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй байгуулав. 2005-2006 онд хэрэглэх ургамал хамгаалах бодисын жагсаалтын төслийг эцэслэн боловсруулж батлуулсан.

“Өрхийн аж ахуйн механикжуулалт – 2005” Олон улсын үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан ба гадаад, дотоодын 40 гаруй аж ахуйн нэгж, сургалт эрдэм шинжилгээний байгууллага, 60-аад нэр төрлийн 300 гаруй техник тоног төхөөрөмж тавьж оролцов. Үзэсгэлэнг 8200 гаруй хүн үзэж сонирхсоны зэрэгцээ нийтдээ 13.0 сая төгрөгийн борлуулалт хийгдэж, 1 тэрбум гаруй төгрөгийн техник, тоног төхөөрөмж авах гэрээ хэлцэл хийгдэв.

БНСУ-ын КОЙКО байгууллагатай говийн болон тал хээрийн бүсийн аймгуудад инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах төслийг хэрэгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурлаа.

Шувууны томуу өвчний оношлогооны арга зүйн талаар НҮБ-ын ХХАА-н байгууллагын экспертүүдтэй хамтран ажиллаж байна.

Монгол, Болгарын ЗГХК-ын хуралдаанд оролцож, “Монгол Улсын Засгийн газар, БН Болгар Улсын Засгийн газар хооронд Ургамал хамгаалал хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Хэлэлцээр”, “Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яам, БН Болгар Улсын Хөдөө аж ахуйн яам хооронд хамтран ажиллах тухай Протокол”-ыг байгуулж, гарын үсэг зурлаа.

НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж буй сүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл, ГТХАН-ийн “Хоршооны менежментийг сайжруулах”, “Мал эмнэлгийн хувьчлалыг дэмжих” төсөл, Швейцарийн Хөгжил хамтын ажиллагааны агентлагийн “Бэлчээр-ногоон алт” төслүүдийн Удирдах хорооны бүрэлдэхүүнийг батлуулан, анхны хуралдаануудыг зохион байгуулав.

Тариалангийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газрын тогтоолоор “Буудай” санг “Тариалан эрхлэлтийг дэмжих сан” болгон зохион байгуулж, аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулахыг зөвшөөрөв. Мөн тогтоолоор Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журмыг батлуулж, энэхүү журмаар Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг зохицуулж байхаар шийдвэрлэсэн.

Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд үрийн буудай олгох ажлыг зохион байгуулж, 30 гаруй аж ахуйн нэгжид 1337 тн үрийн буудай олгов.

Энэ хавар нийтдээ 171.7 мянган га-д үр тариа, 16.2 мянган га-д төмс, хүнсний ногоо, 3.5 мянган га-д малын тэжээлийн ургамал тариалахаар төлөвлөж, одоогийн байдлаар 72.0 мянган га-д үр тариа, 5.8 мянган га-д төмс, хүнсний ногоо тариалаад байна.

БНХАУ-ын Чанарын хяналт шалгалт, хорио цээрийн Ерөнхий газар болон хөдөө аж ахуйн машин техник үйлдвэрлэлийн “КАМКЕ” байгууллагатай “Монгол Улсаас адууны мах экспортлоход хорио цээр, ариун цэврийн шаардлагын талаар байгуулах Протокол”, “Монгол Улсаас ноос, хонь ямааны арьс, үхэр, адууны шир экспортлоход хорио цээр, ариун цэврийн шаардлагын талаар байгуулах Протокол”-д тус тус гарын үсэг зурав.

“Монгол Улсын ХХААЯ болон Францын хил хязгааргүй малын эмч нар ТББ-ын хооронд хамтран ажиллах тухай Санамж бичиг”-т гарын үсэг зурав.

“Монгол Улсын ХХААЯ болон Дэлхийн Зөн Монгол ОУБ хооронд худаг, уст цэгийн хангамжийг сайжруулах тухай Харилцан ойлголцлын Санамж бичиг”-т гарын үсэг зурсан.

БНАСАУ-ын ХАА-н дэд сайд Мүн Ын Жүн тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн айлчлалыг зохион байгуулж, “Монгол Улсын ХХААЯ болон БНАСАУ-ын Хөдөө аж ахуйн яам хооронд хамтран ажиллах тухай Санамж бичиг”-т гарын үсэг зурав.

“Нэг суурин - нэг бүтээгдэхүүн” хөтөлбөр, “Газар тариаланг дэмжих сангийн дүрэм”-ийн төслүүдийг батлуулав.

“Эрчимжсэн мал аж ахуй, шилмэл хээлтүүлэгч хөтөлбөр”-ийн хүрээнд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх болон шилмэл хээлтүүлэгч бойжуулах иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор гэрээ байгуулж, зээл олгов.

Төв аймгийн Баянчандмань суманд төвийн бүсийн малын үзэсгэлэн, үнэ хаялцуулах худалдааг зохион байгуулж 5 аймгийн 400 гаруй мал, амьтан хамруулан гойд ашиг шимт 30 мал, амьтныг шалгаруулав.

Сэлэнгэ аймгийн Шаамар суманд “Зөгий үржүүлэгчид”-ийн сургалт, үзүүлэх сургуулийг 5 аймгийн 50 гаруй зөгий эрхлэгчид оролцуулан зохион байгуулав.

“Шилмэл хээлтүүлэгч”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд зээл олгох аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж байна.

“Хүн амыг эрүүл хүнсээр хангах” зорилгоор Монгол Улсын төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг судалж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна.

Архи, спиртийн үйлдвэрт тоолуур суурилуулах ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэн хяналт тавин ажиллаж байна.

ХААХОУС-гаас хэрэгжүүлж буй “Хөдөөгийн ядуурлыг бууруулах” төслийн хүрээнд Архангай, Булган, Хөвсгөл, Хэнтий аймагт усны шахуурга, цахилгаан үүсгүүр нийлүүлэх гүйцэтгэгч сонгох тендерийг зарлаж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулав.

“Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газар, 230 гаруй иргэн, аж ахуйн нэгж, агро паркт нийтдээ 230 тонн үрийн төмс, 1300 кг хүнсний ногооны үр, 12500 м² хүлэмжийн нийлэг хальс, 240 литр хүнсний ногооны хортон шавьж устгах хор, 140 ширхэг хор цацах гар багаж, 10 тонн био ялзмагт бордоо, 2000 ширхэг жимсний суулгац зэргийг үнэгүйгээр олгох ажлыг зохион байгуулав.

Бага оврын усалгааны төхөөрөмж 30 иж бүрдэл, нийлэг хальсан хүлэмж 24 иж бүрдэл, 0.1 га-гийн дуслын усалгааны систем 40 иж бүрдэл худалдан авах тендер зарлан дүгнэж, 50 хувийн хөнгөлөлттэй үнээр 32 аж ахуйн нэгж, хоршоодод олгох ажлыг зохион байгуулав.

2004-2005 онд үхрийн мялзан өвчний халдваргүй орон болох бэлтгэл ажлын хүрээнд аймгуудаас олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу дээжийг цуглуулан ийлдсийн сан байгуулж, үхрийн мялзан өвчний шинжилгээ хийлээ. Шинжилгээний дүн, бусад шаардлагатай техникийн баримт бичгийг Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын Шинжлэх ухаан, техникийн хороонд хүргүүлж, 2005 оны 5 дугаар сард болсон Дэлхийн Мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын 73 дугаар Ерөнхий чуулганаар Монгол орныг үхрийн мялзангийн халдваргүй орон болохыг зарлаж, батламж авлаа.

“Адууны халдварт цус багасах өвчин, Үхрийн цээж өвчний оношлуур худалдан авах тендер”-ийн баримт бичгийг боловсруулж, тендерийн хорооны хурлаар батлуулав.

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээний хүрээнд Дорнод, Дорноговь, Сүхбаатар, Говьсүмбэр, Өмнөговь, Дундговь, Баян-Өлгий, Ховд аймгийн 66 сум, дүүргийн 4.3 сая малыг дархлаажуулсан байна.

Швейцарийн Хөгжлийн агентлагийн тусламжаар “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын нэгдсэн лабораторийн техник, технологийг сайжруулах” төслийг санхүүжүүлэх Сангийн яам, ХХААЯ, Швейцарийн Хөгжлийн агентлагийн гурвалсан Меморандум боловсруулж гарын үсэг зурах ажиллагааг зохион байгуулав.

БАТЛАН ХАМГААЛАХ

Бодлого төлөвлөлт, гадаад хамтын ажиллагааны чиглэлээр

“Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улс, БНБУ-ын Засгийн газар хоорондын зэвсэг, техник, эд анги буцалтгүй тусламжаар олгох тухай хэлэлцээрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

“Зэвсэг, техникийг бараа солилцооны журмаар гаргах, авахыг зөвшөөрөх тухай” Засгийн газрын нууц тогтоолд өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

БНСУ-ын 12 генерал бүхий төлөөлөгчдийг хүлээн авч, Аляскагийн үндэсний гвардитай хамтарсан семинарыг зохион байгуулан, Зэвсэгт хүчний 84 жилийн ойн арга

хэмжээнд Монгол Улсад байнга болон хавсран суугаа Батлан хамгаалахын атташе нарыг оролцуулав.

“Иракийн эрх чөлөө” Олон улсын ЭСА-нд оролцож буй цэргийн багийн болон “Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үүрэг гүйцэтгэж байгаа Сургалтын хөдөлгөөнт багийн III ээлжийн бүрэлдэхүүнийг IV ээлжийн бүрэлдэхүүнээр солилоо.

Террорист ажиллагаатай тэмцэх үүрэг, зориулалт бүхий хүчний байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах орон тооны бус “зохицуулах зөвлөл”-ийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх төсөл, 2005 оны төсөвт оруулах саналыг боловсруулж, Хүчний байгууллагуудын хамтарсан сургуулийг “Барьцаалагдсан хүн, объектыг чөлөөлөх үеийн ажиллагаа” сэдвээр зохион байгуулж, ТЕГ, ЦЕГ, Дотоодын цэргээс тус бүр нэг, 084 дүгээр ангийн хоёр, 027 дугаар ангиас эмнэлгийн тусламжийн нэг бүлгийг оролцууллаа.

Аймаг нийслэлийн цэргийн штабуудаас хугацаат мэдээнүүдийг авч нэгтгэн, мэргэжлийн мотобуудлагын тусгай батальон байгуулах ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулан, хэсгийн гишүүд тус тусын үүргийн дагуу ажиллаж байна.

Цэргийн албыг дүйцүүлэн хаах сургалтын хөтөлбөрийн төслийг эхний хувилбараар боловсруулан, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эцэслэн гаргах зорилгоор Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн мэргэжилтнүүдтэй хамтран зөвлөгөөн зохион байгуулсан.

Сум, дүүргийн дайчилгааны төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулахад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилгоор Булган, Орхон, Дархан, Хөвсгөл, Завхан аймгуудын дайчилгааны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй семинар зохион байгуулсан.

Батлан хамгаалах салбарын данснаас хасах зэвсэг техник, эд хөрөнгийн талаарх шийдвэрийн хэрэгжилт, батлан хамгаалах салбарын хэмжээнд зэвсэглэл, техник, материал хэрэгсэл, барилга байгууламжийн чанар байдалд үнэлгээ дүгнэлт өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал боловсруулах ажил үргэлжлэн хийгдэж байна.

Зэвсэгт хүчний сургалт бэлтгэл, бэлэн байдлын талаар

2005 оныг Зэвсэгт хүчний хэмжээнд “Монгол Улсын цэргийн дүрмүүд”, “Цэргийн албыг зохион байгуулах заавар”-ын заалтуудыг бүтээлчээр хэрэгжүүлж, цэргийн алба, сахилга, дэг журмыг бэхжүүлж, Зэвсэгт хүчний бүх шатанд хүнлэг, нөхөрсөг уур амьсгал, соёлч харилцааг төлөвшүүлэх жил болгосонтой холбогдуулан Зэвсэгт хүчний холбогдох ангиудын цэргийн алба, сахилга дэг журам, харуул хоногийн манааны үүрэг гүйцэтгэлт, Батлан хамгаалахын сайдын болон ЗХЖШ-ын даргын тушаалын хэрэгжилтэд хяналт шалгалт явуулж илэрсэн зөрчил, дутагдлуудыг газар дээр нь засуулан, холбогдох арга хэмжээг авлаа.

Зэвсэгт хүчний Жанжин штабыг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулж, Зэвсэгт хүчний анги, байгууллагын байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийн түвшинг шалгаж үнэлэх заавар”-ын дагуу анги, байгууллагуудыг шалгаж, байр эзлүүлэх тусгай болзлыг батлуулж, анги байгууллагуудад хүргүүллээ.

Тайван цагт Зэвсэгт хүчинд алба хаах бие бүрэлдэхүүний орон тооны дээд хязгаарыг тогтоох санал, Мотобуудлагын мэргэжлийн тусгай батальоны орон тоог шинэчлэн боловсруулж, аймаг, нийслэлийн цэргийн штабуудаас 2005 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн мэдээг хүлээн авч, нэгтгэн цэргийн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний нэгдсэн тооцоог гаргалаа.

Төрийн холбооны газрын шилэн кабелийг ашиглан БХЯ, ЗХЖШ Төрийн холбооны газрын шилэн кабелиар холбогдлоо.

Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн штабтай явуулах КШС-ийг “Мотобуудлагын тусгай хороог байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэн уулархаг районд тактикийн жижиг бүлгүүдээр байлдааны ажиллагаа явуулах”, 327 дугаар ангийн

штабтай явуулах тусгай үүргийн КШС-ийг “Үйлдвэрийн осол гарсан үед дэмжлэг үзүүлэх мотобуудлагын тусгай хорооны ажиллагаа”, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газартай явуулах КШС-ийг “Болзошгүй террорист ажиллагааны хор уршгийг арилгах үеийн ЗХЖШ, Баянзүрх дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын харилцан ажиллагаа сэдвээр тус тус удирдан явууллаа.

АНУ-ын Тэнгисийн явган цэргийн албан хаагчид Зэвсэгт хүчний анги, салбаруудаас сонгон авсан 130 хүний бүрэлдэхүүнтэй салбар оролцсон Энхийг сахиулах ажиллагааны “Хааны эрэлд-2005” хээрийн сургалт, дадлагыг Таван толгой дахь Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд амжилттай зохион байгуулж явууллаа.

“Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө”-нд оруулж байршуулах Зэвсэгт хүчний материал хэрэгслийн нөөцийн хэрэгцээний тооцоог гаргаж, БХЯ-нд хүргүүлсний гадна Зэвсэгт хүчний байлдааны болон дайчилгааны бэлэн байдлыг дээшлүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулан ЗХЖШ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэлээ.

АНУ-ын Аляска мужид болсон олон улсын агаарын цэргийн хүчний хамтарсан “COPE TUNDRER” хээрийн сургуульд ажиглагчаар АДХЦ-ийн командлагч хошууч генерал Ц.Бямбажав, АДХЦ-ийн харьяа ангиудын 5 офицер, ахлагч нарын хамт оролцлоо.

2004-2005 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч нартай зуны сургалт, хугацаат цэргийн албан хаагчидтай цэргийн ерөнхий бэлтгэл болон тасгийн жигдрэлтийг хангах сургалт, гэрээт цэргийн I, II жилийн цэргийн албан хаагчдын цэргийн ерөнхий бэлтгэл болон мэргэжлийн гүнзгийрүүлсэн сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллалаа.

“Иракийн эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн багийн IV ээлжийн 2 офицер Польш Улсын тэргүүлсэн олон үндэстний “Төв-өмнөд” дивизийн штабт, бусад бүрэлдэхүүн “Чарли” баазад үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

“Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үүрэг гүйцэтгэж байгаа Сургалтын хөдөлгөөнт багийн IV ээлжийн бүрэлдэхүүний үйл ажиллагаа хэвийн, хүндрэлтэй зүйлгүй, хичээл сургууль засварын ажлууд төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.

Монгол Улсын ЗХЖШ-ын даргын урилгаар БНТУ-ын Зэвсэгт хүчний командлагч генерал Хилми Өзкөк, Бельгийн Вант Улсын ЗХЖШ-ын дарга адмирал Август Ван Даэл тэргүүтэй төлөөлөгчид манай оронд албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр манай офицер, ахлагч нарыг өөрсдийн оронд сургаж бэлтгэх, энхийг сахиулах ажиллагаа, цэргийн эмнэлгийн салбарт хамтран ажиллах зэрэг асуудлыг харилцан тохиролцлоо. Эдгээр айлчлал нь Монгол-БНТУ, Монгол-Бельгийн Вант Улсын цэргийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

ЗХЖШ, ОХУ-ын Сибирийн цэргийн тойргийн хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Сибирийн цэргийн тойргийн командлагчийн хүмүүжлийн ажил эрхэлсэн орлогч, Хүмүүжлийн ажлын газрын дарга хошууч генерал Борисенко А.И. тэргүүтэй Сибирийн цэргийн тойргийн төлөөлөгчид айлчлав. Уг айлчлал хоёр талын цэргийн хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд өргөжин тэлж байгааг илтгэн харууллаа.

ГАДААД БОДЛОГО

Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Багабанди БНСВУ, БНАЛАУ-д төрийн айлчлал хийв. Айлчлалын үеэр “Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНСВУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “Монгол Улсын Голомт банк, Вьетнамын Гадаад худалдааны банк хоорондын бизнесийн хамтын ажиллагааны санамж бичиг”, “Монгол Улсын Засгийн газар, БНАЛАУ-ын Засгийн газар хооронд мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”,

“Монгол Улсын Засгийн газар, БНАЛАУ-ын Засгийн газар хооронд ургамал хамгаалал, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг байгуулсан байна.

УИХ-ын дарга асан Н.Энхбаяр тэргүүтэй төлөөлөгчид ОХУ, Австри, Дани, Ирланд Улсуудад тус тус ажлын айлчлал хийлээ.

Монгол, Хятадын хилийг хоёр дахь удаагаа хамтран шалгах хамтарсан комиссын төгсгөлийн хуралдаан болсноос гадна Монгол, Хятадын хилийн боомтын асуудлаар хятадын талтай ноот харилцан солилцов.

Далайн хүчтэй давалгаа /цунами/-д нэрвэгдсэн орнууд тухайлбал Шри Ланка, Индонези, Энэтхэг, Тайландад Монгол Улсын Засгийн газраас 40 мянган ам.долларын тусламж үзүүлээ.

Монгол Улсын Засгийн газар, Румын Улсын Засгийн газар хооронд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологи, эрүүл мэнд, спортын салбарт хамтран ажиллах тухай Хэлэлцээрт гарын үсэг зурж, Испанитай Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих Хэлэлцээрийг үзэглэв.

“Туркийн олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хөтөлбөр зохицуулалтын төлөөлөгчийн газар байгуулах тухай” Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг УИХ соёрхон баталж, хууль гаргасан тул зохих Батламж жуух бичигт гарын үсэг зуруулж бэлэн болголоо.

УИХ-ын дарга асан Н.Энхбаяр, Ерөнхий сайд Ц.Элбэгдорж, Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил нар Монгол Улсад ажлын айлчлалаар ирж ажилласан Канадын Элчин сайд Ж.Кароныг хүлээн авч уулзан хоёр орны харилцааны асуудлаар санал солилцов.

УИХ-ын гишүүн, Монгол-Америкийн найрамдлын бүлгийн дарга Н.Энхболд тэргүүтэй төлөөлөгчид Вашингтон хотноо “Монгол-Америкийн иж бүрэн түншлэл” сэдэвт бага хуралд оролцов. АНУ-ын Конгрессын Америк, Монголын найрамдлын бүлгийн дарга, конгрессын гишүүн Жои Питсс олон улсын терроризмийн эсрэг тэмцэлд манай улсын оруулж буй хувь нэмрийг үнэлж, Төлөөлөгчдийн танхимын хуралдаанд хийсэн мэдэгдэл нь олон улсын терроризмын эсрэг тэмцэх, дайны дараах Иракт гамшгийг арилгах, энхийг сахиулах, сэргээн босгох олон улсын хүмүүнлэгийн ажиллагаанд манай улсын оролцоог Америкийн хууль тогтоогчдод таниулах, хоёр талын харилцааг өргөжүүлэхэд тэдний дэмжлэгийг авахад чухал ач холбогдолтой болсон.

Австралийн Парламентийн танхимын дарга Дэвид Хокер тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчилж, Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нартай уулзав.

Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил Япон Улсад ажлын айлчлал хийж, энэ үеэр “ЭКСПО-2005” олон улсын үзэсгэлэнгийн нээлтэд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж оролцсон ба Японы улс төр, бизнесийн хүрээнийхэнтэй уулзав. Тэрээр Японы Гадаад хэргийн сайдтай хэлэлцээ хийж, Ерөнхий сайд Ж.Койзумид бараалхаж, холбогдох бусад албаны хүмүүстэй уулзлаа. Хэлэлцээ, уулзалтын үеэр Японы тал Монголд ойрын 5 жилд туслах тусгай хөтөлбөрийг өнгөрсөн оны сүүлчээр баталсан тухайгаа мэдээлэв. Монгол Улсын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар 200 сая иенийн буцалтгүй тусламж үзүүлэхээр шийдвэрлэсэн, ЖДҮ-ийг хөгжүүлэхэд 2 шаттай иенийн зээл олгох асуудлаар хэлэлцээ хийх төлөөлөгчдийг ойрын үед Монголд явуулах гэж буйгаа мэдээлэв.

Сайд Ц.Мөнх-Оргил БНСУ-д албан ёсны айлчлал хийн, БНСУ-ын Гадаад хэрэг, худалдааны сайдтай хэлэлцээ хийж, БНСУ-ын Ерөнхий сайдад бараалхав. Яриа хэлэлцээний үеэр Солонгосын Засгийн газар орголт болон бусад шалтгаанаар монгол ажилчдын нэрсийг хөдөлмөрийн бирж дээр байрлуулахаа өнгөрсөн оны 12 дугаар сараас түр зогсоогоод байсныг Гадаад хэргийн сайдын айлчлалтай холбогдуулан сэргээсэн болохыг мэдэгдэв. БНСУ 2005 онд манай улсаас хоёр орны Засгийн газрын хоорондын тохиролцооны дагуу үйлдвэр, барилга, хөдөө аж ахуйн салбарт нийт 2500 ажилчид авахаар болов. Солонгосын тал 2005 онд Монгол 2.5 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэх болсныг мэдэгдэж, цаашид Монгол Улстай уул уурхай, ашигт малтмалын салбарт үр ашигтай хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлэв. Сайд нар Чойр-Сайншандын хатуу хучилттай зам барихад зориулан

БНСУ-ын Засгийн газраас олгож буй 23.9 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн ерөнхий гэрээнд гарын үсэг зурж, Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг үзэглэв.

Сайд Ц.Мөнх-Оргил Пакистаны Исламабад хотод болсон Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээний сайд нарын IV уулзалтад оролцов.

БНТУ-ын ГХЯ-ны Дундад Ази, Кавказ, Зүүн Европын газрын дарга Халил Акынжы Монгол Улсад ажлын айлчлал хийж, Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхаж, ГХ-ийн сайд зэрэг холбогдох хүмүүстэй уулзан, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Сингапур дахь ЕКГ-ыг ЭСЯ болгох тухай асуудлыг шийдвэрлэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Багабанди БНУУ-ын Ерөнхийлөгч Мадл Ференцийн урилгаар БНУУ-д төрийн айлчлал хийсэн. Айлчлалын үеэр Аялал жуулчлал, Эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрүүд, Хөгжлийн хамтын ажиллагааны тухай яам хоорондын Санамж бичиг, 2005-2007 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах яам хоорондын төлөвлөгөө, МУ-ын Онцгой байдал эрхэлсэн сайд, БНУУ-ын Дотоод хэргийн сайд нарын Гамшгаас хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хамтарсан мэдэгдэл зэрэг баримт бичигт гарын үсэг зурав.

Ерөнхий сайд Ц.Элбэгдорж Сингапур Улсад айлчилж, Азийн Эдийн засгийн чуулга уулзалтад оролцов. Мөн Тайландын Вант Улсад айлчилж Ерөнхий сайд Т.Чинаваттай хэлэлцээ хийж мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, аж үйлдвэрийн парк байгуулах зэрэг асуудлаар санал солилцоноос гадна хоёр улсын Гадаад хэргийн яамд хоорондын хамтын ажиллагааны Протокол байгуулав.

Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил Улаанбаатар хотноо болсон “Хүн амын шилжилт хөдөлгөөний асуудлаарх Үндэсний дээд хэмжээний уулзалт” арга хэмжээнд оролцож “Гадаадад шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Монгол Улс Авилгалын эсрэг НҮБ-ын Конвенцид нэгдэн оров.

Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Элбэгдорж Бельгийн Вант Улсад ажлын айлчлал хийж, тус улсын албаны холбогдох хүмүүстэй уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар яриа хэлэлцээ хийлээ. Ерөнхий сайд Европын Комиссын Боловсрол, соёл, олон хэлтний асуудал хариуцсан комиссартай уулзаж, Монгол Улс-Европын Холбооны хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, ялангуяа хөгжлийн хамтын ажиллагаа, эдийн засаг, худалдаа, боловсролын салбарт хамтран ажиллах боломжийн талаар санал солилцлоо. Ерөнхий сайдын Бельгийн Вант Улсад хийсэн айлчлал Монгол-Бельгийн улс төр, эдийн засаг худалдааны харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал түлхэц болсон.

Ерөнхий сайд Ц.Элбэгдорж Нидерландын Вант Улсад айлчлан, тус улсын Цог Жавхлант Хатан хаан II Беатрикс бараалхаж, Нидерландын Ерөнхий сайд, Ерөнхий сайдын орлогч, Сангийн сайд, Хөгжлийн хамтын ажиллагааны сайд нартай тус тус уулзаж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны болон харилцан сонирхсон асуудлаар яриа хэлэлцээ хийлээ. Энэхүү айлчлал нь хоёр орны улс төрийн харилцааг эрчимжүүлэх, хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, хөгжлийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

Ерөнхий сайд Ц.Элбэгдорж Холбооны Канцлер Г.Шредерийн урилгаар ХБНГУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын хүрээнд Германы Бундестагийн дэд Ерөнхийлөгч, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн сайд, Эдийн засаг, хөдөлмөрийн яамны Парламентын Төрийн нарийн бичгийн дарга, Боловсрол судалгааны яамны Парламентын Төрийн нарийн бичгийн дарга нартай уулзан, хоёр талын харилцааны асуудлаар санал солилцов. Энэ үеэр хоёр орны харилцаа идэвхтэй хөгжиж байгааг цохон тэмдэглээд цаашид өргөжүүлэн хөгжүүлэх талаар хүчин чармайлт гаргахаа хоёр тал харилцан илэрхийлсэн байна.

БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч У И Монгол Улсад айлчилж, Шадар сайдтай хэлэлцээ хийж, Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нарт бараалхав. Уулзалт хэлэлцээний үеэр үр дүнд БНХАУ Монгол Улсад 50 сая юанийн буцалтгүй тусламж үзүүлэх болсон байна.

Монгол Улсад Япон Улсаас үзүүлэх 300 сая иений буцалтгүй тусламжийн тухай ноот бичиг, хүний нөөцийг хөгжүүлэх тусламжийн хүрээнд Монголоос 20 хүн магистрын сургалтад хамруулах тухай ноот бичигт тус тус гарын үсэг зурсан.

БНЧУ-ын Парламентын төлөөлөгчдийн танхимын дарга тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр УИХ-ын Тамгын газар болон Чехийн Парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав.

Туркийн ТИКА-ийн Ерөнхийлөгч Монгол Улсад айлчилж, Хархорин-Орхоны хөндийн 46 км зам тавих тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурав.

Соёлын биет бус өвийг хамгаалах тухай ЮНЕСКО-гийн 2003 оны Конвенцийг соёрхон батлах тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газар, УИХ-ын чуулганы хуралдаанаар тус тус хэлэлцүүлж батлуулав.

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сангийн хооронд хэрэгжүүлж буй 2002-2006 оны Хамтын ажиллагааны хөтөлбөрийн дунд хугацааны тайлангийн хурлаас гаргасан зөвлөмжийн төслийг хөтөлбөр болгон өргөжүүлэх замаар Хамтын ажиллагааны хөтөлбөрт тодотгол хийх тухай Санамж бичигт талууд гарын үсэг зурлаа.

“АРФ-ын орнуудын аюулгүй байдлын үзэл баримтлалд гарч буй өөрчлөлт” сэдэвт олон улсын семинарыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, АРФ-ын гишүүн 50 орны төлөөлөгчид оролцсон.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРЭГ

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-аар хэлэлцүүлж батлуулав. Мөн “Шүүхийн шинжилгээний үндэсний төв байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэлээ.

Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аар батлуулав.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын эрх зүйн сургалт сурталчилгааны асуудал хариуцсан ажилтнуудын ээлжит семинарыг ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол” академи, Хууль зүйн үндэсний төвтэй хамтран, Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал сэдэвт семинарыг Соросын сан, соёл урлагийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран тус тус зохион байгуулж явууллаа.

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Ц.Сүхбаатар Франц Улсын элчин сайд ноён Жакуес Оливер Маненттийг, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Алтангэрэл АНУ-ын Элчин сайдын яамны цэргийн атташе, БНТУ-ын Элчин сайдын яамны III нарийн бичгийн дарга ноён Семих Лутфу Тургут, Швейцарын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Консул ноён Маркус Дубах нарыг тус тус хүлээн авч уулзав.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд заасны дагуу “Цагдан хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам”-ыг батлав.

Мэдээллийн аюулгүй байдлын тухай, Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмал гар аргаар олборлох тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгч, УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын 1966 оны Пактын хэрэгжилтийн талаар Монгол Улсын ээлжит Үндэсний илтгэлийг бичих, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг 1984 оны Конвенцийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын анхны илтгэл бичих, гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүмүүсийн эрхийг хамгаалах асуудлаарх ажлын хэсгийн уулзалтыг тус тус зохион байгуулав.

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Ц.Сүхбаатар тэргүүтэй төлөөлөгчдийн ОХУ-д хийсэн айлчлалын үеэр Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Оросын Холбооны Улсын Мансууруулах бодисын эргэлтэд хяналт тавих холбооны алба хооронд Мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийн эргэлттэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай, Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсэн.

УИХ-ын сонгуулийн тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай, Монгол Улсын хууль тогтоомжийг системчлэх тухай, Олборлон боловсруулж байгаа зарим төрлийн ашигт малтмалд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай болон Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд өгөх Засгийн газрын санал дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн урилгаар БНУУ-ын Хууль зүйн сайд Пэтритэй Йожэфын Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалыг зохион байгууллаа. Энэ айлчлалын үеэр хоёр орны эрх зүйн салбарын харилцааг өргөжүүлэхэд чиглэгдсэн дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тохиролцлоо. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын хооронд холбоо тогтоон хамтран ажиллах
- Яам хооронд хамтран ажиллах Хөтөлбөр боловсруулж батлах
- Нарийн мэргэжлийн сургалт зохион байгуулах

НҮБ-ын Эрүү шүүлтийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Манфред Новакийн Монгол Улсад айлчлав. Тусгай илтгэгч Манфред Новак нь Монгол Улсад эрүүдэн шүүхийг хориглох, тэмцэх талаар хийж байгаа ажлуудтай танилцсан бөгөөд урьдчилан хорих байр, зарим хорих ангиудаар биечлэн явж, нөхцөл байдалтай танилцсан.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг 1984 оны Конвенцийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын илтгэлийг бичих ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулж илтгэх бэлтгэх сэдвээр Хүний эрхийн үндэсний комисстой хамтран сургалтыг зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайд, ЗГХЭГ-ын даргын харьяа агентлагуудаас хийж гүйцэтгэсэн ажлын талаар

УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

Улс, аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын албадын бүтэц, орон тоог шинэчлэн баталлаа. Энэхүү бүтцийн өөрчлөлт нь Мэргэжлийн хяналтын байгууллагын орон тоог нягтруулах, ажил үүргийн давхардлыг арилгах чиглэлд хийгдсэн томоохон алхам юм. Мөн төв, орон нутгийн мэргэжлийн

хяналтын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий Дотоод хяналт, мониторингийн газрыг иргэд, олон нийттэй харьцах, мэдээлэл солилцох албатайгаар зохион байгууллаа.

Тус газраас “2005 оныг өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах жил” болгож зарлаж, улсын болон орон нутгийн төсвийн захиран зарцуулалтад хийж буй санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг барагдуулах, төсвийг зориулалтын бус зүйлд зарцуулах, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулахыг даалгах, харьяалах дээд байгууллагад нь шалгалтын дүнгийн талаар мэдэгдэх зэргээр төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.

Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг нийслэлийн төвийн 6 дүүргийн Үйлдвэрлэл, тохижилт үйлчилгээний хэлтэс болон Тохижилт үйлчилгээний компаниуд, мөн нийслэлийн хог хаягдлын төвлөрсөн цэгийг хариуцдаг Нөөц компаний үйл ажиллагааг шалгахад дүүрэг хороодын засаг дарга нар нутаг дэвсгэртээ хог хаягдлыг бууруулах, Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажилладаггүй, хог хураамжийн орлогыг хог цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд зарцуулдаггүй, тохижилт үйлчилгээний компаниуд хог хаягдал зайлуулах болон тохижуулах ажлыг зохих шаардлагын дагуу гүйцэтгэж чадахгүй байгаа зэрэг зөрчил дутагдал илэрснийг арилгуулах талаар нийслэл, дүүргийн засаг дарга, тохижилт үйлчилгээний компаниудад улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Япон Улсад болсон гамшигт нэрвэгдэгсдэд туслах сайн санааны хөдөлгөөнд хандив өргөсөн байгууллага, иргэдийн хандивын мөнгийг Японы талд хүлээлгэн өгөв.

“Гамшгаас хамгаалах зорилт-2005” улсын зөвлөгөөнийг зохион байгуулав.

Галын аюулаас урьдчилан сэргийлэх хяналтыг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмч хөрөнгөнд гал түймрийн улмаас шууд ба шууд бусаар хохирол учруулж болох сөрөг үр дагаврыг бууруулахад онцгой анхааран ажиллаж байна.

Монгол-Оросын Засгийн газрын хамтарсан комиссын бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын ээлжит V хуралдаанд оролцож, хил орчмын нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангах хамтын ажиллагааг идэвхжүүлэх талаар мэдээлэл солилцов.

Боом өвчин гарсны улмаас Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт багийн нутаг “Борын хоолой” гэдэг газар тогтоосон хорио цээрийн дэглэмийг цуцалсан бөгөөд Ялалт багийн нийт 17 мянга шахам толгой малыг боомын эсрэг вакцинд хамруулсан байна.

ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО

“Дулааны цахилгаан станц-2” төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцааг нэг багц болгон нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах тендерийн хуваарь, зар мэдээ, хувьчлах доод үнэд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Төрийн өмчийн хорооны хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.

Авто зам засвар, арчлалтын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох тухай Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэхээр ТӨХ-ны хуралд уг асуудлыг оруулж тогтоол гаргуулав.

“Дулааны II цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн нийт хувьцааг нэг багц болгон нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлан худалдах, худалдан авах гэрээний төслийг ТӨХ-ны хуралдаанаар хэлэлцэж батлав.

Монгол, Оросын хамтарсан “Эрдэнэт” үйлдвэр, “Монголросцветмет” нэгдлийн Зөвлөлийн хурал болж, “Эрдэнэт” үйлдвэрийн удирдлагын бүрэлдэхүүнийг Оросын

талын саналыг харгалзан хэвээр үлдээхээр, “Монголросцветмет” нэгдлийн гүйцэтгэх захиралтай холбоотой асуудал шүүх, цагдаагийн байгууллагаар шийдэгдэх тул үүрэг гүйцэтгэгч томилов.

“Говь”, “МИАТ”, Булганы “Эрдэнэ суврага” ХК-иудын төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг төрийн өмчийн хорооны хуралд оруулж шийдвэрлүүлэв

Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн эд хөрөнгийг “Монголросцветмет” нэгдлийн менежментийн багаас хүлээн авав.

МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО, ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

“Цахим Засгийн газар” мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг БНСУ-ын “KIPA” агентлагтай хамтран яам, агентлагууд, орон нутаг, хувийн хэвшлийнхнийг хамруулсан судалгаа хийсэн.

Улаанбаатар-Дашинчилэн чиглэлийн шилэн кабелийн сүлжээ байгуулах арга хэмжээний хүрээнд тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалтын ажлыг дуусгаж, техник, тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын болон техникийн комисст урьдчилсан байдлаар хүлээлгэж өглөө.

“Төрийн байгууллагуудын мэдээллийн дотоод сүлжээ, интранет ашиглах загвар журам”, “Төрийн байгууллагуудын вэбэд суурилсан үйлчилгээний журам” ба газрын дотоод үйл ажиллагаатай холбогдох 5 багц журмын төслүүдийг боловсруулан батлаад байна.

Монгол Улсын хүн ам, айл, өрх, албан байгууллагуудын компьютерийн хэрэглээ, хангамжийн өнөөгийн байдал, цаашдын эрэлт хэрэгцээ, хандлагын талаарх “Цахим хувьсгал” судалгаа хийж дуусгалаа.

Олон улсад холбогдох өргөн зурвас бүхий интернэтийн нэгдсэн гарцтай болох, интернэтийн хэрэглээг нэмэгдүүлэх талаар “Улаанбаатар төмөр зам” болон “Орбитнэт” ХХК-тай хамтран ажиллах, Засгийн газрын мэдээлэл, холбооны сүлжээг шинэчлэх “Ай Пи утас” төслийг БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэхээр тус улсын “Зи-Ти-И” компанитай хамтран ажиллах санамж бичигт тус тус гарын үсэг зурав.

ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙГ ХЯНАН ЗОХИЦУУЛАХ ТАЛААР

Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлтэй танилцаж зах зээлийн эрэлтэд нийцүүлэн үйл ажиллагааны төрлөөр багцлан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах үнэ цэнэтэй томоохон аж ахуйн нэгжүүдийн судалгааг хийв.

Зах зээлд дангаар ноёрхож байгаа болон давамгайл байдалтай аж ахуйн нэгжүүдийг тогтоох зорилгоор улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 25.0 мянга гаруй аж ахуйн нэгжүүдийн 2003-2004 оны борлуулалтын орлого, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 2003-2004 онуудад импортоор авсан 15.4 мянган нэр төрлийн барааны тоо хэмжээ, үнийн судалгааны талаар мэдээллийн сан бүрдүүлээ.

Агентлагийн үйл ажиллагааны чиг үүргийг сурталчлах, шударга өрсөлдөөний талаарх ойлголтыг олон нийтэд цэгцтэй хүргэх, хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлох зорилгоор “Шударга өрсөлдөөн-бизнесийн амжилт” сэдэвт цуврал уулзалт ярилцлагыг зохион байгуулав.

Дэлхийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран Вашингтон дахь Дэлхийн банкны төвтэй видео ярилцлага зохион байгуулж, олон улсын зөвлөх ажиллуулах, техникийн тусалцаа авах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл солилцов.

“Шударга өрсөлдөөн-бизнесийн амжилт” сэдэвт цуврал уулзалт, ярилцлагыг зохион байгуулсан бөгөөд “Зах зээл-өрсөлдөөн” сэдэвт чөлөөт хэлэлцүүлгийг зохион

байгууллаа. Хэлэлцүүлэгт УИХ, яам, агентлаг, ТББ, бизнесийн байгууллага, эрдэмтэн судлаачид зэрэг 115 төлөөлөгчид оролцлоо.

Олон улсын өрсөлдөөний байгууллагын холбоонд элсэх хүсэлт гаргасны хариуд тус агентлагийг 82 дахь орны 93 дахь гишүүн байгууллагаар бүртгэн авсан болно.

ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР

Шинэ бүтээлийн 98 мэдүүлэг хүлээн авч, бүрдлийг хянан бүртгэв. Шинэ бүтээлийн нийт 114 мэдүүлэгт хайлт, шүүлт хийн магадлан дүгнэлт гаргасан. Шинэ бүтээлийн 79 патентын 207 эзэмшигчид патент олгуулахаар Монгол улсын Шадар сайдын тушаалын төслийг хуулийн хугацаанд боловсруулан шийдвэрлүүлсэн байна.

282 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд оюуны өмчийн болон зар сурталчилгааны хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийснээс зөрчилтэй байсан 33 байгууллага аж ахуйн нэгж, иргэдэд 7 470 000 төгрөгийн торгуулийн захиргааны арга хэмжээ авч, 2 669 740 төгрөгийн зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг улсын байцаагчийн 48 акт үйлдэн хурааж, зөрчилтэй байсан 119 аж ахуйн нэгжид улсын байцаагчийн мэдэгдэл өгч, шүүх цагдаагийн байгууллагад 2 аж ахуйн нэгжийн материалыг хуулийн дагуу шийдвэрлүүлэхээр шилжүүлээд байна.

Цагдаа болон шүүхийн байгууллагаас ирүүлсэн захирамж, шийдвэрийн дагуу 7 шинжээчийн дүгнэлт гаргаж, улсын байцаагчийн 119 мэдэгдлийг зөрчил арилгуулахаар өгч холбогдох арга хэмжээг авахуулсан ба нийт явуулсан шалгалтаар 258 иргэд, аж ахуйн нэгж зөрчилтэй болох нь тогтоогдоод байна.

“Хүүхдийн оюуны бүтээмжийн ертөнц” үзэсгэлэнг Ёс зүй - Эх орон холбоотой хамтран зохион байгуулав.

Оюуны өмчийн газрын “Мэдээллийн төв”-ийн үйл ажиллагааг нээж, оюутан залуус болон иргэдэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх боломжийг нэмэгдүүлэв.

“Оюуны өмчийн эрх зүйн зохицуулалт” сэдэвт сургалтыг Сүхбаатар, Дорнод аймгуудад зохион явууллаа. Сургалтад аймгуудын шүүх, прокурорын ажилтан албан хаагчид болон ХХК-ний менежер, инженер техникийн нийт 70-аад ажилтан хамрагдав.

Швейцарь улсын Женев хотноо зохион байгуулагдсан ДООБ-ын “Барааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар, газар зүйн заалт”-ын Байнгын хорооны 14 дахь удаагийн чуулганд оролцов.

БНХАУ-ын ООБ-ын урилгаар Бээжин хотноо ООБ-н дарга Н.Чинбат тэргүүтэй төлөөлөгчид ажлын айлчлал хийв.

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ АСУУДЛААР

Хүүхдийн утасны сүлжээ “Найз-1979” ажиллуулах зөвшөөрлийн гэрчилгээ авч, холбогдох газруудтай гэрээ хийгээд байна.

“Нийгмийн цогц суурь үйлчилгээ хөтөлбөр, өрхийг чадваржуулах стратегийн хэрэгжилтэд салбарын дэмжлэг сэдэвт уулзалт зохион байгуулав.

Нийслэлийн Цагдаагийн газрын Олон нийттэй харилцах хэлтэстэй хамтран “Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хэлэлцүүлсэн.

UBS child суваг, FM-107.5 радиотой 2005 онд хамтран ажиллах гэрээ байгуулан графикайн дагуу эмзэг бүлгийн болон халамжийн төвийн 3 хүүхдийг радио, теле нэвтрүүлэгт оролцуулж, тэдний санаа бодлыг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулав.

УДИРДЛАГЫН АКАДЕМИ

ХБНГУ-ын Олон улсын чадавхийг дэмжих “Инвент” байгууллагатай хамтран ажиллах 3 жилийн санамж бичигт гарын үсэг зурав. Энэхүү санамж бичиг нь академийн

Төрийн удирдлагын сургуулийн сургалтын чанарыг сайжруулах, түүнчлэн багш нарыг бэлтгэх, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

“Сургалтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх арга зам” сэдэвт ажил хэргийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулав. Ажил хэргийн уулзалтаас гарсан зөвлөмжийн дагуу “Сургалтын хөтөлбөрийг сайжруулах”, “Багшийн ёс зүйн дүрэм” боловсруулах ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байна.

АНУ-ын Хавайн их сургуультай хамтран зохион байгуулах “Зүүн хойд Ази ба Монгол Улс” сэдэвт Олон улсын бага хурлын бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.

“Засгийн газрын тэтгэлэгт сургалтад элсэгчдийг сонгон шалгаруулах журам”, Төрийн захиргааны удирдлага мэргэжлээр бакалаврын зэрэг олгох сургалтын элсэлтийн түр журам”, “Удирдлагын академийн элсэлтийн журам” болон “Удирдлагын академийн элсэлтийг орон нутагт зохион байгуулах журам”-ын шинэчилсэн найруулгыг батлав.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академи, БНСУ-ын Нутгийн удирдлагын хөгжлийн институтын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж, Удирдлагын академийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр БНСУ-ын Нутгийн удирдлагын хөгжлийн институтийн ерөнхийлөгч Ли Квон-Санд Удирдлагын академийн Хүндэт доктор цол өргөмжлөв.

ТӨР ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, АЖ АХУЙГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордны хэвийн ажиллагаа, тав тухтай орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарч, энэ ажлын хүрээнд томоохон ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Газрыг түшиглүүлэн байгуулсан мэргэжлийн түр сургалтын төвд Засгийн газрын Ш, IY байрын захиргааны үйлчилгээний ажилтнуудыг хамруулан сургаж 34 хүнд “үйлчлэгч”-ийн мэргэжил олгов. Ингэснээр тус газрын хэмжээнд мэргэжилгүй ажилтан байхгүй болж, мэргэшсэн агентлаг болох зорилтыг хэрэгжүүлэхэд нэгэн томоохон алхам хийв.

Төрийн ордны заал, танхимуудад 199 удаагийн төвлөрсөн арга хэмжээ зохион байгуулагдсаны дотор Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээ болов.

Цахилгаан, дулаан, барилга засвар, мужаан, цайны ыолон мод, цэцэг, ногоон байгууламжийн үйлчилгээний технологийн зааварчилга, стандартуудыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулан мөрдөж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Индонез, Унгар Улс, Ерөнхий сайдын Малайз, Сингапур Улсад хийх айлчлалын төсвийг боловсруулан батлуулж, гадаад томилолт, аж ахуй үйлчилгээний бэлтгэлийг хангаж ажиллав.

Төрийн ордны зүүн жигүүрийн цэвэр, бохир усны сүлжээг бүхэлд нь сольж шинэчлэв. Мөн давхар бүрийн цайны өрөө, ариун цэврийн өрөөнүүдэд засвар тохижилт хийж, тоноглолуудыг шинээр суурилуулав.

Дулаан цэвэр усны төв шугамд ус зөөлрүүлж, зэв арилгах төхөөрөмж шинээр суурилуулан тоноглов. Төрийн ордны халаалтын системийн узельд нөөцийн 2 насос шинээр суурилуулсан нь аваар осолгүй хэвийн ажиллагааг хангахад чухал нөөц хэрэгсэл болсон.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

----- о О о -----